



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөө баталсан:

Тамгын хэлтсийн дарга,
эрхэлсэн комиссар

Төсвийн Шууд захирагч

З.Баасанням

Төлөвлөгөөг хянасан:

Авлигатай тэмцэх газрын дарга,
Тэргүүн комиссар

Төсвийн Ерөнхийлөн захирагч

З.Дашдаваа

2021.01.11



**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Дэд салбар	Зорилтын	Арга хэмжээний
		тоо	
№	УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, ЗГ-ын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан” АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”	10	37
	Гүйцэтгэлийн зорилт №1.1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх		2
	Гүйцэтгэлийн зорилт №1.2. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах;		8
	Гүйцэтгэлийн зорилт №1.3 Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах;		2
	Гүйцэтгэлийн зорилт №1.4 Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах;		1
	Гүйцэтгэлийн зорилт №1.5 Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах;		1
	Гүйцэтгэлийн зорилт №1.6 Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах;		1
	Гүйцэтгэлийн зорилт №1.7 Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах;		6
	Гүйцэтгэлийн зорилт №1.8 Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах;		4
	Гүйцэтгэлийн зорилт №1.9 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны тайлан мэдээ хүлээн авах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан боловсруулж, хүргүүлэх;		1
	Гүйцэтгэлийн зорилт 1.10 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, заавар, зөвлөгөө өгөх, хамтарч ажиллах;		11
№	Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө (2020-2023)	45	35
1.	Стратегийн зорилго 1: Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа судалгаа шинжилгээ, технологид тулгуурлан хэрэгжинэ.	13	11
2.	Стратегийн зорилт 2: Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа олон нийтэд түшиглэдэг болно.	12	5
3.	Стратегийн зорилго 3: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлага нэвтэрсэн байна.	7	14
4.	Стратегийн зорилт 4: Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажил хамтын ажиллагаанд тулгуурладаг болно.	8	3
5.	Стратегийн зорилго 5: Мэдлэг чадвартай хүний нөөц, мэргэшсэн албан хаагчдад тулгуурлан байгууллагын чадавхи бэхжинэ.	5	2
	Нийт	55	72

---000---

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах:

Гүйцэтгэлийн зорилт №1.1. **Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.1 дүгээр арга хэмжээ- Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох;				
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 4.1.1.1, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.1.1-1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	ХШДШХ, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар			
	Суурь түвшин	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг нээлттэй болгох ажлыг цахим системд тулгуурлан олон нийтэд ил тод, нээлттэй байршуулахаар ажиллаж байна. Одоогийн байдлаар зөвхөн цахим системээр гаргасан мэдүүлэг гаргагч болон холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг хянасан дүгнэлт, холбогдох албан бичгийн мэдээллийг системээс харах боломжтой байгаа.			
	Шалгуур үзүүлэлт	Дүгнэлт нээлттэй, ил тод болгох ажил хэвшсэн байна.			
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *ХАСУМ-ийг цахимаар мэдүүлэх талаарх саналыг авч, програмд хөгжүүлэлтийг хийсэн байна. *ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох мэдээллийн хүрээ, хэлбэрийг тодорхойлж, албажуулсан байх; Сүүлийн хагас жилд: *ХАСУМ-ийг цахимаар бүртгүүлэх байгууллагын тоо 2 дахин нэмэгдсэн байна. *Мэдээлэл ил, тод нээлттэй болох ажил хэвшсэн байна.			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.2 дугаар арга хэмжээ- Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах;				
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 4.1.1.1, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.1.5, Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.5;			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	США, Ахлах комиссар Ц.Шинэбаяр, УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн,			
	Суурь түвшин	“Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээ” хийх ажлыг Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрыг хамруулан зохион байгуулж, үнэлгээний үр дүнг тухайн байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сангийн авлигын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлж, эхлэлтийн болон явцын тайланг хүлээн аваад байна.			
	Шалгуур үзүүлэлт	*Авлигын эрсдэлийн үнэлгээ хийгдэж, дүн шинжилгээ хийж, дүнг олон нийтэд мэдээлэгдсэн байх; *Эрсдэлд суурилсан арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцсон байх;			
	Хүрэх түвшин	*Хэлтэс, албадын үйл ажиллагааны уялдааг хангаж, эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцсон байх;			

Гүйцэтгэлийн зорилт №1.2. **Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах;**

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.1 дүгээр арга хэмжээ- Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 4.1.5.4-1-д заасан арга хэмжээ				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	-2020 онд “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл”-ийн 2014 оны I, II боть, 2011-2012 оны шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг 1 боть болгон хэвлүүлсэн. -2013, 2015 оны шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг хэвлэлтэд шилжүүлэв. -2016, 2017, 2018, 2019 оны шүүхийн шийдвэрийг эмхэтгэн боловсруулж байна.				
	Шалгуур үзүүлэлт	-Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах -Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашигласан байх				
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: 2013, 2015, 2016, 2017, 2018, 2019, 2020 оны шүүхийн шийдвэрийг эмхэтгэн боловсруулж дуусган хэвлэлтэд шилжүүлэн дуусгаж, дүн шинжилгээ хийх 2 дугаар улиралд: Төрийн байгууллагуудаас авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд мэдээлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх 3 дугаар улиралд: Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан үүсгэн, сургалтад ашиглах 4 дүгээр улиралд: Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан үүсгэн, сургалтад ашиглах				

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.2 дугаар арга хэмжээ- Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан үүсгэх;					
Арга хэмжээний нэр, дугаар	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 4.1.5.11-1				
	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө	30,000,000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн 2011-2018 оны шийдвэрүүдийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийхэд зорилгоор эмхэтгэн цэгцэлж, 2011-2015 оны шүүхийн шийдвэрийг хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан. Судалгаа хийх хүснэгтийг боловсруулж, мэдээллийг цуглуула ажил хийгдэж байна.				
	Шалгуур үзүүлэлт	* 2016-2020 оны шүүхийн шийдвэрийг цуглуулж, эмхэтгэсэн байх; *Мэдээллийн сан үүсгэж, баяжилтыг хийж байх; *Дүн шинжилгээ хийх нөхцөлийг хангасан байх.				
	Хүрэх түвшин	1 дугаар улиралд: *2016-2020 оны шүүхийн шийдвэрүүдийг цуглуулах, шаардлагатай тохиолдолд ШЕЗ-өөс авч, шийдвэрийг бүрэн цуглуулж, сан үүсгэсэн байх; *2016-2020 оны шүүхийн шийдвэрүүдийг судалгааны хүснэгтийн дагуу мэдээллийг бүрэн бөглөсөн байх 2 дугаар улиралд: *2016-2020 оны шүүхийн шийдвэрийг он дарааллаар эмхэтгэж, хяналтын уншлагыг хийсэн байх; *Эмхэтгэлийн хэвлэлийн эхийг бэлтгүүлж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан. *Шүүхийн шийдвэрийн цахим сангийн өгөгдлийн загварыг боловсруулж, цахим сангийн хөгжүүлэлтийг хийлгэх бэлтгэлийг хангасан байх; 4 дүгээр улиралд: *Шүүхийн шийдвэрийн цахим мэдээллийн санг хөгжүүлж, авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлсэн байх.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.3 дугаар арга хэмжээ- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн цахим санг хөгжүүлэх;				
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 7.2, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.7-3, АТГ-ын стратеги төлөвлөгөө (2020-2023)-ний зорилт 3, арга хэмжээ 1.7			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	40,0 сая			
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, АБХШНАлба, Ахлах комиссар Т.Энхболд			
	Суурь түвшин	khutulbur.iaac.mn цахим мэдээллийн санг үүсгэсэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн 2019 оны тайлангийн мэдээллийг санд оруулсан. Цахим санд мэдээлэл оруулах талаар хэрэгжүүлэгч байгууллагуудын ЭБАТ-ыг 2019, 2020 онд арга зүйн сургалтад хамруулсан. Цахим санд 3 дэд санг хөгжүүлж, програм хангамжийг бэлэн болгосон.			
	Шалгуур үзүүлэлт	*Мэдээлэл оруулах эрхтэй албан тушаалтны бүртгэлийг шинэчилсэн байх; *Мэдээлэл боловсруулах, санд оруулах албан тушаалтныг арга зүйн сургалтад хамруулсан байх; *Хөтөлбөрийн хэрэгжилтийн 2020 оны мэдээллийг санд оруулах ажлыг зохион байгуулсан байх; *Програм хангамжийг өргөтгөн дэд сангуудыг үүсгэх, хөгжүүлэлтийг хийсэн байх.			
	Хүрэх түвшин	1-р улиралд: *Мэдээлэл оруулах эрхтэй албан тушаалтны бүртгэлийг шинэчилж, өөрчлөгдсөн тохиолдолд нэвтрэх эрхийг шинээр олгож, арга зүйгээр хангасан байх; *Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр ажилласан, сахилгын шийтгэлийн, зөвлөмжийн дэд сангийн мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулсан байх; 2-р улиралд: *Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын 2020 оны тайланг санд оруулах ажлыг зохион байгуулсан байх; *Сургалтын, тушаал шийдвэр хянасан мэдээллийн сангуудыг шинэчлэн хөгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дэд санг шинээр үүсгэн хөгжүүлэлт хийлгэх ажлыг зохион байгуулсан байх; 3-р улиралд: *Шүүхийн шийдвэрийн дэд санг шинээр үүсгэн хөгжүүлэлт хийлгэх, хөгжүүлэлтийг хийлгэсэн дэд сангуудыг туршилтыг хийж, мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулсан байх 4-р улиралд: *Дэд сангуудыг үндсэн мэдээллийн сангуудтай холболт хийх, саналыг боловсруулж, шийдвэрлүүлж, уялдаа холбоог хангасан ба			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.4 дүгээр арга хэмжээ- Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санд олон нийттэй харилцах цэс үүсгэж, хамрах хүрээг, үр нөлөөг нэмэгдүүлэх; /Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар мэдээлэл өгөх сүваг/				
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 4.1.5, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.9-2;			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн, АБХШНАлба, Ахлах комиссар Т.Энхболд			
	Суурь түвшин	Үндэсний статистикийн хорооноос 2019.12.26-ны өдөр А/196 дугаар тушаалаар олгосон зөвшөөрлийн дагуу АТГ-ын 2020.01.02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 30, захиргааны 6 маягт, тэдгээрийг нөхөх заавар, өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн шийдвэрлэлтийн, зүйлийн мэдээний маягт, заавар, гэмт хэргийн тоо бүртгэлийн зааврыг тус тус баталгаажуулсан. Энэхүү маягт зааврын дагуу гэмт хэргийн шинжтэй гомдол, гэмт хэргийн мэдээллийн улсын албан ёсны статистикийг бүрдүүлж байгаа.			
	Шалгуур үзүүлэлт	Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санд олон нийттэй харилцах цэсийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх;			
	Хүрэх түвшин	1-р улиралд: *Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санд олон нийттэй харилцах цэс үүсгэх судалгаа хийгдэж, техникийн болон бусад шийдлүүд гарсан байна. *Ажлын даалгавар боловсрогдсон байх; 2-р улиралд: *Олон нийттэй харилцах цэсийг үүсгэж, туршилт хийгдсэн байх; 3-р улиралд: *Зохицуулалт тодорхой болж, сурталчилгаа хийгдсэн байх; *Үйл ажиллагаа хэвшсэн байх;			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин			
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.5 дугаар арга хэмжээ- Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын давтан сургалтын болон хуульч бэлтгэгдэг сургуулиудын сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгасан эсэхэд дүн шинжилгээ хийх, тусгуулах арга хэмжээ авах;			
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.5, 2.1.10-д заасан зорилт, 4.1.5.12, 4.1.10.2-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.12-1, 4.1.10.2-2, АТГ-ын стратеги төлөвлөгөө (2020-2023)-ний стратегийн зорилго С2-3, арга хэмжээ 2.11		
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-		
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн		
	Суурь түвшин	Хуульч бэлтгэгдэг сургуулиудын сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгасан эсэхэд дүн шинжилгээ асуудлаар БСШУСЯ яам болон “Монголын Их, дээд сургуулийн консорциум” ТББ-ыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгууллаа. Дүн шинжилгээнд 21 их, дээд сургууль хамрагдсан ба нийт 78 хичээлийн агуулгаар 2017 онд 5,514 оюутан, 2018 онд 6,183 оюутан, 2019 онд 6,031 оюутан 610 цагийн Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг судалсан гэсэн дүгнэлт гарсан болно. Уг дүгнэлтэд үндэслэн 2020-2022 онд нийт 21 их, дээд сургуулийн 70 судлагдахуун хичээлийн агуулгаар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв”-ийг 610 цаг судлахаар сургалтын хөтөлбөрт тусгуулах арга хэмжээг аваад байна. Харин УЕПГ-ын дэргэдэх Сургалтын төв, ШЕЗ-ийн дэргэд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, ХЗҮХ зэрэг сургалт зохион байгуулж буй сургалтын байгууллагуудын 2019 оны хөтөлбөрт дүн шинжилгээ хийх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна		
	Шалгуур үзүүлэлт	*Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын давтан сургалтын талаар эрх зүйн орчин, албан хаагчдыг давтан сургах үйл ажиллагааны төлөвлөлт, баримталж буй бодлого, тэдгээрийн хэрэгжилтийг судалсан байх, *Санал боловсруулсан байх		
	Хүрэх түвшин	2-р улиралд: *Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгасан байдалд дүн шинжилгээ хийсэн байх;		
		3-р улиралд: *Дүн шинжилгээнд тулгуурлан давтан сургалтын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар сэдэв, агуулгыг тусгасан эсэх талаар санал боловсруулсан байх. *Сургалтын хөтөлбөрт тусгуулах арга хэмжээ авах;		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин			
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.6 дугаар арга хэмжээ- Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх;			
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.5-д заасан зорилт, 4.1.5.13, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.13		
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-		
	Хариуцах нэгж	ХШДШХ, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар		
	Суурь түвшин	Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангиал, зэрэглэл өөрчлөгдсөн, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолоор төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн баталсан, мөн Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 275 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаал”-ын ангиал, зэрэглэл, 276 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээ”-ний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Авлигын эсрэг хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоол буюу ХАСХОМ гаргах албан тушаалтны хамрах хүрээнд өөрчлөлт орсон талаарх, мөн Төрийн болон нутгийн захиргааны нийт 109 байгууллагаас мэдүүлэг гаргагчдын хамрах хүрээнд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг судалгааг авч нэгтгэн боловсруулсан.		
	Шалгуур үзүүлэлт	*Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗАСЗУСТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулахаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгааг хийсэн байна. *Судалгаа, үзэл баримтлал, төслийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилсан байна.		

		*Батлагдсан тохиолдолд сурталчилгааны ажлыг бие даан болон ЭБАТ-уудын тусламжтайгаар зохион байгуулсан байна.
	Хүрэх түвшин	2-р улиралд: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулахаар Хууль тогтоомжийн тухай хуульд судалгаа, үзэл баримтлал, төслийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилсан байна.
		3. 4-р улиралд: *Сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, нэг мөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин			
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.7 дугаар арга хэмжээ- Хууль бус нөлөөллийн хэлбэрийг оновчтой тодорхойлох;			
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.5-д заасан зорилт, 4.1.5.15, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.15		
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-		
	Хариуцах нэгж	ХШДШХ, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар		
	Суурь түвшин	-		
	Шалгуур үзүүлэлт	Хууль бус нөлөөллийн хэлбэрийг тодорхойлох, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалны үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг судлах, мэдүүлгийн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох үйл ажиллагааг оновчтой тодорхойлох зорилгоор 737 эрх бүхий албан тушаалтнаас судалгаа авсан.		
	Хүрэх түвшин	2-р улиралд: *Судалгааны дүнг үндэслэн танилцуулга, хэлэлцүүлэг хийх, санал зэрэг арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байх; 3-р улиралд: *хууль тогтоомжид тусгах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг судалж саналыг уламжилсан байх;		

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1.8 дугаар арга хэмжээ- Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах асуудлыг судалж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах;				
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18.4.2, АТҮХ-ийн 2.1.5-д заасан зорилт, 4.1.5.16-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.16-1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням			
	Суурь түвшин	Авлигын эсрэг хуулийн 6.1.9-д зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө АТГ-аас санал авахаар тусгагдсан. *Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг батлуулахаас өмнө АТГ-аас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмжийг авдаг байхаар буюу Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг ХЗДХЯаманд уламжилсан.			
	Суурь түвшин	Авлигын эсрэг хуулийн 6.1.9-д зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө АТГ-аас санал авахаар тусгагдсан.			
	Шалгуур үзүүлэлт	-Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар, яамдаас батлан мөрдүүлсэн дүрэм, журмыг судалсан байх; -Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд Засгийн газар, яамдаас батлан мөрдүүлсэн дүрэм, журмыг судалсан байх; -Санал боловсруулсан байх.			
	Хүрэх түвшин	2-р улиралд: -Хууль тогтоомжийн тухай хуульд судалгаа хийх -Захиргааны ерөнхий хуульд судалгаа хийх -Засгийн газар, ХЗДХЯ-аас баталсан дүрэм, журмуудад судалгаа хийх			
3-р улиралд: -Нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр шинээр эрх зүйн зохицуулалт бий болгох, эсхүл мөрдөгдөж буй дүрэм, журмын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой эсэх талаар санал боловсруулсан байна.					

Гүйцэтгэлийн зорилт №1.3 **Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах;**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.3.1.1 дүгээр арга хэмжээ- Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.6-т заасан зорилт, 4.1.6.2-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.6.2-1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	30 000 000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Шударга өрсөлдөөн, хууль дээдлэх үзлийг төлөвшүүлэх, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор судлаач П.Мөнхтогттой хамтран “Нийгмийн хариуцлагын бүрэн зураглал” гарын авлага бэлтгэн гаргалаа. Уг гарын авлагыг төрийн өмчит компани болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд тарааж, Эрдэнэт үйлдвэр ТӨК-ийн 200 албан хаагчийг хамруулан сургалт зохион байгуулсан. Хувийн хэвшилд зориулсан ашиг сонирхлын зөрчлийн 12 төрлийн хориглолт, хязгаарлалтын тухай 5 модуль бүхий интерактив хичээл боловсруулж, жүжигчилсэн хэлбэртэй зохиол болгож, интерактив сургалтын модулийг програм хангамж руу буулгаж, аппликейшн бүтээх гүйцэтгэгчийн талаарх судалгааг хийж байна.				
	Шалгуур үзүүлэлт	Сургалтын бэлтгэл ажлыг хангаж, сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;				
	Хүрэх түвшин	1-р улиралд: -Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг сургалт хамрагдсан болон хамруулах хүний тоо, сэдвийн талаар судалгаа, санал авч нэгтгэж төлөвлөгөө боловсруулах -Сургалтын хөтөлбөр, хуваарь, танилцуулгыг боловсруулж, сургалтын бэлтгэлийг хангах -Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах -Сургалтын төлөвлөгөөний биелэлт, сургалтын үнэлгээний санал асуулгын нэгдсэн дүн, бус тоо баримтуудыг нэгтгэж илтгэх хуудас боловсруулах 2-4-р улиралд: -Сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын хөтөлбөр, хуваарь, танилцуулгыг боловсруулж, сургалтын бэлтгэлийг хангах; -Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах; -Сургалтын төлөвлөгөөний биелэлт, сургалтын үнэлгээний санал асуулгын нэгдсэн дүн, бус тоо баримтуудыг нэгтгэж илтгэх хуудас боловсруулах				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.3.1.2 дугаар арга хэмжээ- Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй бодлого, тогтолцоог санаачилж хэрэгжүүлсэн байгууллагыг урамшуулах механизм бүрдүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж санал боловсруулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.6-д заасан зорилт, 4.1.6.3-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.6.3-4, АТГ-ын стратеги төлөвлөгөө (2020-2023)-ний стратегийн зорилго С2-2, арга хэмжээ 2.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	20 000 000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Авлигын эсрэг үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагад олон улсын байгууллагаас олгодог шагналын талаар судалгаа хийж, төрийн бус байгууллагуудад зориулсан шагнал бий болгох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан.				
	Шалгуур үзүүлэлт	-Судалгаа, шинжилгээ хийсэн байх; -Олон улсын туршлага судалсан байх; -Санал боловсруулж, танилцуулсан байх.				
	Хүрэх түвшин	1-р улиралд: Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын туршлага судалсны үндсэн дээр санал боловсруулж, танилцуулсан байна. 2-р улиралд: Саналд оруулсан засвар, нэмэлт, өөрчлөлтийг тусгасан байна.				

Гүйцэтгэлийн зорилт №1.4 **Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах;**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.4.1.1 дүгээр арга хэмжээ- Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх, хамтран ажиллах;

Арга хэмжээний нэр, дугаар	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, АТҮХ-ийн 2.1.7-д заасан зорилт, 4.1.7.4-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.4-1, 4.1.7.4-2, 4.1.7.4-3,				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх, хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ, судалгаа, бүрэлдэхүүнийг томилсон шийдвэр, 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мэдээллээр сан үүсгэн, нэгтгэн дүгнэсэн. Орон нутагт 2020 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр мэдээлэл арга зүйгээр хангах, мэдээлэл солилцох онлайн уулзалтыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулав. Онлайн уулзалтад 21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус салбар зөвлөлийн дарга, Нарийн бичгийн дарга нар оролцсон бөгөөд тэдгээрт "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр мэдээлэл хийсэн. ГХУСА33-ийг авлигын эсрэг үйл ажиллагаанд татан оролцуулах чиглэлээр санал, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний, биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүнг нэгтгэн гаргасан.				
	Шалгуур үзүүлэлт	-Авлигын эсрэг хууль тогтоомж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээр нийцүүлэн гаргасан дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан байна. -Нийслэл, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр дүн нэмэгдсэн байна.				
	Хүрэх түвшин	1 дугаар улиралд: *Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар санал, чиглэл боловсруулж хүргүүлэх ажлыг зохион байгуулах; *Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр чадавхижуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах онлайн уулзалтыг зохион байгуулах. 2 дугаар улиралд: *Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс орон нутагт авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургагч багш бэлтгэх, чадавхижуулах ажлыг зохион байгуулах. 3, 4 дүгээр улиралд: *Сургагч багшаар дамжуулан орон нутгийн иргэдэд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтэд дүн шинжилгээ хийж, манлайлан ажилласан зөвлөлийг олон нийтэд сурталчлах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.				

Гүйцэтгэлийн зорилт №1.5 Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах;

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.5.1.1 дугаар арга хэмжээ- Эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд сургалт зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.10-т заасан зорилт, 4.1.8.1-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.8.1-2				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	20 000 000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Авлига, бусад гэмт хэрэг, зөрчлийн чиглэлээр дагнан ажилладаг болон эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан танхимын сургалт зохион байгуулахаар "Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв" ТББ-тай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулсан. 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр "Авлига ба эрэн сурвалжлах сэтгүүлчид" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 25 сэтгүүлчийг сургалтад хамруулав.				

	Шалгуур үзүүлэлт	*Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд зориулсан сургалт зохион байгуулсан байх; *Эрэн суралжлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сурвалжлагч, сэтгүүлч нарт зориулсан сургалт зохион байгуулсан байх.
	Хүрэх түвшин	1-р улиралд: Сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна. 2-р улиралд: Сургалтыг зохион байгуулж, үр дүнг үнэлсэн байна.

Гүйцэтгэлийн зорилт №1.6 **Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах;**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.6.1.1 дугаар арга хэмжээ- Улс төрийн намын удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх; ХАСХОМ-ийг олон нийтэд мэдээлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.9-т заасан зорилт, 4.1.9.6-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.9.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	ХШДШХ, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар, Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж мөрдөгдсөнтэй холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороотой хамтран УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгууллаа. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-ыг шинэчлэх ажлын хүрээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудаас санал авч, төслийг боловсруулж байна. Уг төсөлд УИХ-д суудалтай улс төрийн намын удирдах албан тушаалтан ХАСХОМ гаргуулахаар тусгах боломжийг судалж байна.				
	Шалгуур үзүүлэлт	Улс төрийн намын удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих зохицуулалтын талаар судалгаа хийж, санал боловсрогдсон байна.				
	Хүрэх түвшин	2-р улиралд: Санал боловсрогдож, эрх бүхий байгууллагад уламжлах нөхцөл бүрдсэн байна. 3-р улиралд: Батлагдсан тохиолдолд мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна.				

Гүйцэтгэлийн зорилт №1.7 **Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах;**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.1 дүгээр арга хэмжээ- Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэгчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.10-т заасан зорилт, 4.1.1.10, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1-1, АТГ-ын Стратеги төлөвлөгөө С2-2.7				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	60 000 000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	*2020 онд 93 удаа сургалтад 6725 иргэн, 6965 төрийн албан хаагч, нийт-13820 хүнийг хамруулж, 2190 хүнд “Facebook live” сургалт хийж, нийслэлийн 9 дүүргийн 143 хорооны 1631 албан хаагчийг цахим сургалтад оролцууллаа. Сургалтыг салбар, мэргэжил тус бүрээр төрөлжүүлэн зохион байгуулсан нь шинэлэг байв. Онлайн, Фэйсбүүк Лайв, Zoom meeting online цахим холболт ашиглан 20 удаагийн сургалтыг зохион байгуулсан.				
	Шалгуур үзүүлэлт	*Сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байх, биелэлтийг тооцож байх; -Цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтын тоог нэмэгдсүүлсэн байх				
	Хүрэх түвшин	Жилдээ: Иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.2 дугаар арга хэмжээ- Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.10-д заасан зорилт, 4.1.10.1, 4.1.10.2, 4.1.10.3-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1-2, 4.1.10.2-2, 4.1.10.3-1, Байгууллагын стратеги төлөвлөгөө С2-2.2				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	20.0 сая				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	-2020 онд авлигын эсрэг агуулга бүхий 20 төрлийн зурагт хуудас, “Төрийн албан хаагч танаа”, “Шударга ёсны үнэ цэнэ”, Авлигын шилэн бөмбөлөг”, “Хожихгүй нүүдэл” “Авлигын эсрэг улам олуулаа нэгдье” 5 контент, “Гэрлээ асаа”, “Хуулийн дагуу төл, үйлийн үрээ ч эдэл”, “Шударга ёсны төлөө нэгдье”, “Үр”, “Тангараг,” “Аавын захиас” 7 богино хэмжээний шторк, кино, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утасны сурталчилгаа, “Шударга тоглоё” хүүхэлдэйн зохиомж, “Шударга ёс” цувралын эхний анги болох “Хичээл дээр” теле зохиомжийг бүтээж, Зохиолч, сэтгүүлч, нийтлэлч нартай хамтран ажилласнаар шударга ёсны сэдвээр богино хэмжээний 20 өгүүллэг, 6 нийтлэл, 4 ярилцлага, 15 тодруулга бэлтгэн, бүтээлийн фонд бүрдүүлэх, 37 төрлийн 16.962 ширхэг ном, гарын авлага, тараах материалыг түгээсэн. SBN телевизтэй хамтран мэдээлэл, баримт, фактад тулгуурласан “Баримтын хайрцаг” 3 удаагийн цуврал нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд хүргэлээ. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аян, арга хэмжээг зохион байгуулж, “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулган, “Ковид ба авлига: Иргэдийн чөлөөт индэр” цахим хэлэлцүүлэг, сэтгүүлчдийг оролцуулан 15 шторк, 20 постер хийж, сурталчлан “Шударга ёс: Хичээл дээр...”, “Шударга тоглоё” видео контентоор бүжгийн челленж өрнүүлэв. “Цахим сэтгүүл зүй” ТББ-тай хамтран баримтад суурилсан “Өөр өнцөг” нэвтрүүлгийг бэлтгэв. Зохиолч Н.Мандалтай гэрээ байгуулан хүүхдэд зориулсан жүжгийн зохиол бичүүлж байгаа.				
	Шалгуур үзүүлэлт	*Авлигын эсрэг сурталчилгааны материалыг хэвлэмэл, аудио, видео гэсэн 3 үндсэн нэр төрлөөр бэлтгэсэн байх; *Сурталчилгааны материалыг шууд 5000 хүн, шууд бусаар 100.000 хүнд хүргэсэн байх. *“Шударга ёс, хөгжил дэвшилд #110” подкастыг төлөвлөгөөний дагуу 10-аас доошгүй дугаар бэлтгэн, түгээсэн байх, хөгжүүлэлтийг тогтмол хийсэн байх; *Монголын Хүүхэлдэйн театртэй хамтран хүүхдүүдэд зориулсан жүжгийн найруулгыг хийж, зохиолыг тайзнаа тоглуулах;				
	Хүрэх түвшин	1 дугаар улиралд: *Зорилтот бүлгийн онцлогийг харгалзан зурагт хуудасны сэдэв, агуулгын төлөвлөгөө гаргаж, 3 төрлийн сурталчилгааны материалыг бэлтгэж олон нийтэд хүргэсэн байх; *“Шударга ёс, хөгжил дэвшилд #110” подкастын сэдэв, агуулгын төлөвлөгөөний дагуу 2 видео контентыг бүтээж түгээсэн байх; *Соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулсан байна. *Хүүхдэд зориулсан жүжгийн зохиолыг эцэслэн хүлээн авч танилцсан байх; 2 дугаар улиралд: *“Шударга ёс, хөгжил дэвшилд #110” подкастын сэдэв, агуулгын төлөвлөгөөний дагуу 3 видео контентыг бүтээж түгээсэн байх; *Монголын Хүүхэлдэйн театртэй хамтран хүүхдүүдэд зориулсан жүжгийн найруулгыг хийсэн байх; *Соён гэгээрүүлэх аяныг зохион байгуулсан байх; 3 дугаар улиралд: Сурталчилгааны материалыг боловсруулж, олон нийтэд хүргэсэн байх; *“Шударга ёс, хөгжил дэвшилд #110” подкастын сэдэв, агуулгын төлөвлөгөөний дагуу 2 видео контентыг бүтээж түгээсэн байх; *Монголын Хүүхэлдэйн театртэй хамтран хүүхдүүдэд зориулсан жүжгийн зохиолыг тайзнаа тоглуулсан байх; Сурталчлах ажлыг зохион байгуулсан байх; *Соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулсан байна. 4 дүгээр улиралд: Сурталчилгааны материалыг боловсруулж, олон нийтэд хүргэсэн байх; *“Шударга ёс, хөгжил дэвшилд #110” подкастын сэдэв, агуулгын төлөвлөгөөний дагуу 3 видео контентыг бүтээж түгээсэн байх; *Соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.3 дугаар арга хэмжээ- Авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлыг зохион байгуулах;

Арга хэмжээний нэр, дугаар	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.10-д заасан зорилт, 4.1.10.2, 4.1.10.3-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.2-2, 4.1.10.3-1, АТГ-ын стратеги төлөвлөгөө (2020-2023)-ний зорилт СЗ-3, арга хэмжээ 2.10				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	45.0				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Хувийн хэвшилд ажиллагсдад зориулсан ашиг сонирхлын зөрчлийн 12 төрлийн хориголт, хязгаарлалтын тухай 5 модуль бүхий интерактив хичээл боловсруулсан. “Шударга ёс-Иргэний хяналт” чадавхжуулах сургалтын хөтөлбөр (14.75 хэвлэлийн хуудас) боловсруулж, уг хөтөлбөрийг 3 өдөрт багтаан хэрэгжүүлэх 9 цагийн лекц, 9 цагийн дасгал, 3 цагийн хэлэлцүүлгээс бүрдсэн, хөтөлбөрийг боловсруулж, туршилт сургалт хийн баталгаажуулсан. Тайлант хугацаанд 16 гарын авлага, эмхэтгэл, 2 тойм танилцуулгыг бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулав.				
	Шалгуур үзүүлэлт	-Иргэдэд зориулсан авлигын эсрэг мэдлэг, ойлголт олгох гарын авлагыг боловсруулж хэвлүүлсэн байх; -Гарын авлагыг иргэдэд хүргэж, хэлэлцүүлэн, үр дүнг үнэлсэн байх; -Хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан байх; -Сургалтын хөтөлбөр, модулийг туршсан байх.				
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: Иргэдэд зориулсан авлигын эсрэг мэдлэг, ойлголт олгох гарын авлагыг боловсруулсан байх; *2020 онд боловсруулсан төрийн албан хаагчдад зориулсан гарын авлагыг хэвлүүлсэн байх; *2020 онд боловсруулсан иргэд болон иргэний нийгмийн байгууллагын сургалтын хөтөлбөр, гарын авлагыг хэвлүүлсэн байх; *2021 онд боловсруулж, хэвлүүлэх сургалтын хөтөлбөр, гарын авлагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, нэгдсэн жагсаалтыг гаргасан байх; 2 дугаар улиралд: *Гарын авлагыг хэвлүүлж, иргэдэд түгээсэн байна. *Нэгдсэн жагсаалтын дагуу гарын авлага, хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулсан байх; 4 дүгээр улиралд: *Иргэдэд зориулсан авлигын эсрэг мэдлэг, ойлголт олгох гарын авлагыг иргэдээр хэлэлцүүлж, үр дүнг үнэлсэн байна. *Сургалтын хөтөлбөр, гарын авлагыг хүлээн авч, туршилт сургалтыг зохион байгуулж, туршсан байна. Цаашид сургалт хөтөлбөрийн дагуу явдаг болсон байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.4 дүгээр арга хэмжээ- Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.10-д заасан зорилт, 4.1.10.2-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.2-3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	2020 онд “Залуус өөрчлөлтийн төлөө”, “Богд” судалгааны хүрээлэн” “Хуулийн хөтөч клуб” зэрэг ТББ-тай хамтран ЕБС-ын сурагчдыг хамруулсан “Авлигагүй нийгэм, сурагчдын оролцоо” /“New generation no corruption”/ сэдэвт илтгэх урлагийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хүүхэд багачуудад зориулан бүтээсэн “Шударга ёс” цувралын эхний анги “Хичээл дээр” контент, “Шударга ёс” цувралын дараагийн ангиудын зохиолын уралдаан, MN Agency” ХХК-тай гэрээ байгуулан “Шударга Монголын төлөө” уриатай “Шударга тоглоё” дуун дээр бүжгийн цахим челленжийг өрнүүлсэн.				
	Шалгуур үзүүлэлт	*Өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг, уралдаанд оюутан, сурагч, эцэг эхийг хамруулсан байх; *Өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг, уралдаан бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж, дүгнэсэн байх.				
Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: Оюутны болон сурагчдын холбоо, эцэг эхийн зөвлөл, холбоотой хамтран ажиллах талаар санал солилцох уулзалтууд зохион байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө гаргана.					
	2 дугаар улиралд: Хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. Гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулсан байна.					
	4 дүгээр улиралд: Хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ бүрэн биелсэн байна. Үр дүнг хэлэлцсэн байна.					

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.5 дугаар арга хэмжээ- Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2.1.10, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.10.4.1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүй зэрэг зорилтот салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагын удирдлага, гишүүдийг сургагч багшаар бэлтгэх цахим сургалтыг 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нийт 25 иргэнийг хамруулан зохион байгуулж, цахим гарын авлага, сургалтын материалаар хангав. Мөн сургалтын дараа сургалтын санал асуулга явуулж, дүнг нэгтгэн гаргасан.				
	Шалгуур үзүүлэлт	*Өмнөх жилүүдэд бэлтгэсэн сургагч багш нарын бүртгэлийг шинэчилж, сургалт, сурталчилгаа хийлгэх ажлыг эрчимжүүлсэн байх; *Сургагч багш бэлтгэх шаардлага салбар, зорилтот бүлгээс сургагч багш шинээр бэлтгэж чадавхижуулсан байх; *Сургагч багш нарын хийсэн сургалт, сурталчилгааны тоо, хамрагдсан хүмүүсийн талаар мэдээллийг нэгтгэн үр дүнг тооцсон байх; *Бага дунд сургуулийн багш нараас сургагч багш бэлтгэх; *Нийслэл, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд сургагч багш бэлтгэх; *Сургагч багш нараар дамжуулан авлигын эсрэг сургалт, сурталчилгааны ажлыг хийж, үр дүнг тооцсон байна.				
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: *Сургагч багш бэлтгэх, өмнө бэлтгэсэн сургагч багшийн үйл ажиллагааг идэвхижүүлэх чиглэлээр санал боловсруулж, сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх; 2 дугаар улиралд: *Өмнө нь бэлтгэсэн сургагч багш нараар дамжуулан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; *Нийслэл, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд сургагч багш бэлтгэн чадавхжуулах ажлыг зохион байгуулах; *Бага дунд сургуулийн багш нараас сургагч багш бэлтгэн чадавхжуулах ажлыг зохион байгуулах; *Их дээд сургуулийн багш нарыг сургагч багшаар бэлтгэж чадавхижуулах ажлыг зохион байгуулах.				
		4 дүгээр улиралд: Сургагч багш нараар дамжуулан авлигын эсрэг сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.7.1.6 дугаар арга хэмжээ- Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.10-д заасан зорилт, 4.1.10.1-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1-3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	-				
	Шалгуур үзүүлэлт	-Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг тогтмолжуулж, эргэх холбоо үүсгэсэн байх; -Иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнг үнэлж дүгнэсэн байх.				
	Хүрэх түвшин	1-р улиралд: Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлын механизмыг бүрдүүлсэн байна. 2-р улиралд: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах эргэх холбоог батжуулсан байна.				

Гүйцэтгэлийн зорилт №1.8 Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.8.1.1 дүгээр арга хэмжээ- Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын өөрийн үнэлгээний тайлан боловсруулж, хүргүүлэх, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах;					

	Төлөвлөлтийн уялдаа:	АТҮХ-ийн 2.1.11-д заасан зорилт, 4.1.11.2-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.11.2-1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	30 000 000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	- Гүйцэтгэх ажлын тоо бүртгэлийн програм хангамж, түүний мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор шинээр DELL NX маркийн сервер худалдан авч ажиллагаанд нэвтрүүлээд байна. Ингэснээр тоо бүртгэл, дүн шинжилгээний програмын мэдээлэл цуглуулах, ажиллах чадварыг нэмэгдүүлж, Дүн шинжилгээ, хайлтын хэсгийн ажиллах хурд, боломжийг нэмэгдүүлсэн.			
	Шалгуур үзүүлэлт	*Гүйцэтгэх ажлын тоо бүртгэлийг нэгдсэн сангийн мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх программ хангамжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажлын даалгавар боловсрогдсон байх, *Гүйцэтгэх ажлын тоо бүртгэлийг нэгдсэн сангийн мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх программ хангамжийг боловсруулсан байх;			
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Гүйцэтгэх ажлын тоо бүртгэлийг нэгдсэн сангийн мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх программ хангамжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажлын даалгавар боловсрогдсон байх, Сүүлийн хагас жилд: *Гүйцэтгэх ажлын тоо бүртгэлийг нэгдсэн сангийн мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх программ хангамжийг /75 хувь/ боловсруулсан байх;			

Гүйцэтгэлийн зорилт №1.11.5 Мэдлэг чадвартай хүний нөөц, мэргэшсэн албан хаагчдад тулгуурлан байгууллагын чадавхи бэхжинэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.5.1 дүгээр арга хэмжээ- *Хүний нөөцийн бодлогын баримт бичигт боловсруулж, хэрэгжүүлэх;				
	Төлөвлөлтийн уялдаа:	АТГ-ын стратеги төлөвлөгөө (2020-2023)-ний зорилт С5-1, арга хэмжээ 5.1			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням			
	Суурь түвшин	*Байгууллагын стратеги төлөвлөгөөг 2020.01.02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар баталсан. 2020 олд онд Хүний нөөцийн хөтөлбөрийг сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөртэй хамтатган боловсруулсан.			
	Шалгуур үзүүлэлт	*Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, төсөв батлагдсан байна.			
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, төсөв батлагдсан байна. Сурталчлах ажил зохион байгуулагдсан байна. Сүүлийн хагас жилд: Бодлогын баримт бичгийн төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилт хангагдсан байна.			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.11.5.2 дугаар арга хэмжээ- *Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх сургалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг чадавхижуулах;				
	Төлөвлөлтийн уялдаа:	АТГ-ын стратеги төлөвлөгөө (2020-2023)-ний зорилт С5-1, арга хэмжээ 5.3			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	150,000,0			
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням			
	Суурь түвшин	Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах журам"-д нийцүүлэн сургалтын бодлогын баримт бичиг боловсруулсан.			
	Шалгуур үзүүлэлт	*Сургалтын бодлогын баримт бичиг, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, төсөв батлагдсан байна.			

	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Сургалтын бодлогын баримт бичиг, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, төсөв батлагдсан байна. *Сурталчлах ажил зохион байгуулагдсан байна. Албан хаагчдыг төрийн худалдан авах ажиллагаа, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, эрсдэлийн удирдлага болон холбогдох бусад сургалтад системтэйгээр суралцуулсан байна. Худалдан авах ажиллагааны сургалтад нийт албан хаагчдын 15 хувийг хамруулна. Сүүлийн хагас жилд: Албан хаагчдыг төрийн худалдан авах ажиллагаа, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, эрсдэлийн удирдлага болон холбогдох бусад сургалтад системтэйгээр суралцуулсан байна. Худалдан авах ажиллагааны сургалтад нийт албан хаагчдын 15 хувийг хамруулна.
--	--------------	---

---000---



ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

/ ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ /

№	Эрх зүйн акт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.	9	12
18.1.1.улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;			
18.1.2.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;			
18.1.3.авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх;			
18.1.4.төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;			
18.1.5.авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;			
18.1.6.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;			
18.1.7.төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.			
18.4.4.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;			
Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.Авлигатай тэмцэх газар дараахь бүрэн эрхтэй: 18.4.2.авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах; 18.4.3.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;			
2.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, ХАСУМ-ийг хянах, төлөвлөгөөт болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ. УИХ-ын Хуульзүйн байнгын хорооны тогтоол №05, №20-ын хэрэгжилтийг хангана.	18	5
18.2.1.хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;			
18.2.2.мэдүүлэг гаргаагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.			
18.4.13.хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;			
18.4.14.хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;			
18.4.15.мэдүүлэг гаргаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;			
18.4.16.хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;			
18.4.6.авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;			

28.1 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:			
28.1.2.энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар.			
23.3.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.			
23.6.Авлигатай тэмцэх газар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг ажлын 10 өдөрт багтаан хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.			
13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т зааснаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.			
13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.			
13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.			
24.3. Авлигатай тэмцэх газар хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө.			
26.1. Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 24.1.2-т зааснаас бусад хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.			
26.3. Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.			
26.4.Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.			
26.5.Улсын Их Хурлын гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.			
3.	Хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах	1	8
18.4.11.хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх,			
18.4.7.хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах 18.5.Авлигатай тэмцэх газар Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр тодорхой хэргийг цагдаа, тагнуулын байгууллагатай хамтран шалгаж болно.			
8.6.Авлигатай тэмцэх газар нь тодорхой хэрэгт гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, энэ хуульд заасан журмыг баримтална.			
Нийт		28	25

---000---

**ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН**

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ, НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ,
АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ**

Гүйцэтгэлийн зорилт №2.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэлийн зорилт № 2.1.1. Авлигын эсрэг хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулах зохицуулах, арга зүйн удирдлагаар хангах.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.1 дүгээр арга хэмжээ- Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, АТҮХ-ийн 2.1.10-д заасан зорилт, 4.1.10.1-т заасан үйл ажиллагаа, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1-4				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	15 000 000				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	2017 оноос хойш төрийн байгууллагуудын авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг АТГ-аас үнэлж, дүгнээгүй. Авлигын эсрэг үйл ажиллагааг төрийн байгууллагууд хэрхэн үр дүнтэй төлөвлөх, тайлагнах, арга зүйг боловсруулах, энэ талаарх сайн туршлагыг солилцох зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын төлөвлөлт, үр дүнг сайжруулах-арга зүйн асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг засаглалын судалгааны чиглэлээр ажилладаг судлаач нарыг оролцуулан зохион байгуулж, судлаачид төлөвлөлтийг сайжруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох чиглэлээр авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний загварыг хэд хэдэн хувилбараар боловсруулж, Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллахаар тогтоов.				
	Шалгуур үзүүлэлт	*Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагуудыг нийтлэг байдлаар хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний үр дүнг хэрхэн тооцох талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх; *khutulbur.iaac.mn цахим мэдээллийн санд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дэд сан үүсгэх ажлыг зохион байгуулах; *Төрийн байгууллагуудаас тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийсэн байх.				
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: *Төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, нийтлэг байдлаар хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний үр дүнг хэрхэн тооцох талаар чиглэл хүргүүлэх, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах *khutulbur.iaac.mn цахим мэдээллийн санд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө дэд цэс үүсгэх ажлыг зохион байгуулах				
		2 дугаар улиралд: Төрийн байгууллагуудаас явцын тайлан авч, дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах				
		3 дугаар улиралд: Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах				
		4 дүгээр улиралд: Төрийн байгууллагуудаас төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.2 дугаар арга хэмжээ- Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, иргэний санал, санаачилгыг дэмжин туслах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4, АТҮХ-ийн 2.1.7-д заасан зорилт, 4.1.7.4-т заасан үйл ажиллагаа				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө					
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	*Авлигаас урьдчилан сэргийлэх талаар санал, санаачилгыг дэмжин, оролцоог нэмэгдүүлж ажиллаж чиглэлээр нийт 26 ТББ, 11 иргэн, 1 төрийн өмчит судалгааны байгууллага, 87 компанитай гэрээ байгуулж, ажилласан байна.				

	Шалгуур үзүүлэлт	*Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний 30% нь иргэд, олон нийт, ТББ-ын оролцоонд тулгуурласан байх.
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: ТББ, иргэний санал, санаачилгыг өрнүүлэхэд чиглэсэн фокус уулзалт, ярилцлагыг 10-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. 2 дугаар улиралд: Ажлын даалгавар боловсруулж, сонгон шалгаруулсан 5-аас доошгүй иргэн, ТББ-аар гэрээт ажлыг гүйцэтгүүлсэн байна. 3 дугаар улиралд: Гэрээний үндсэн дээр сургалт, сурталчилгааны ажлыг 5-аас доошгүй иргэн, ТББ-аар гүйцэтгүүлсэн байна. 4 дүгээр улиралд: Хамтран ажилласан иргэд, ТББ-ын жагсаалт, зарцуулсан төсөв, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг боловсруулна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.3 дугаар арга хэмжээ- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, авлигад өртөх боломжийг багасгах талаар Зөвлөмж боловсруулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, ил тод, нээлттэй байдлыг хангуулах чиглэлээр ЗГХЭГ, Сангийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын төрийн нам, УИХ-ын сонгуульд нэр дэвшигч зэрэг 18 байгууллагад 85 асуудал бүхий Зөвлөмж 19, 21 аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт 7 асуудал бүхий 1, нийт 20 Зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.				
	Шалгуур үзүүлэлт	*Хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн байх; *Ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн байх; *Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.				
	Хүрэх түвшин	Жилдээ: Зөвлөмжийн биелэлтийг тооцсон байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.4 дүгээр арга хэмжээ- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах, ёс зүйн дүрмийн төсөлд санал өгөх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	2020 онд Эрүүл мэндийн салбарын 1, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны 10, боловсролын салбарын 1, гаалийн салбарын 6, эрчим хүчний салбарын 1, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 1, зам тээврийн салбарын 1, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 1, гадаад харилцаа, байгаль орчны 2, нийт 18 дүрэм, журам, шийдвэрийг хянан үзлээ.				
	Шалгуур үзүүлэлт	*АТГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/183 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ын шаардлага хангасан байх; *act.iaac.mn цахим бүртгэлийн системд бүртгэлийг оруулсан байна.				
	Хүрэх түвшин	Салбарт тус бүрт хамаарах 2-оос доошгүй дүрэм, журам, шийдвэрийг хянан үзэж, үр дүнг танилцуулсан байна. Мөн act.iaac.mn цахим бүртгэлийн системд оруулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.5 дугаар арга хэмжээ- Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг хэрэгжилтийг хангах, сан хөтлөх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5				
	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө	-
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн
	Суурь түвшин	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчил гарсан нь тогтооёдож, сахилгын шийтгэл хүлээсэн 25 албан тушаалтны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд дахь “Сахилгын шийтгэл” цэсэнд байршуулахын зэрэгцээ пэйж хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэв.
	Шалгуур үзүүлэлт	*АТГ-ын даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийн холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын шаардлагыг хангасан байх; *Журмын шаардлагыг хангасан өгөгдлийг бүрэн тусгасан сан хөтөлсөн байх; *Иргэд, олон нийтэд мэдээлсэн байх.
	Хүрэх түвшин	*Сахилгын шийтгэлийн цахим дэд санд мэдээлэл байршуулах ажлыг зохион байгуулах, шинээр ирсэн бичгийг хүлээн авч бүртгэлд тухай бүр байршуулж, албан бичгийн мөрөөр ажиллаж байгаа мэдээ, илтгэх хуудсыг нэгтгэж, тоо мэдээг улирал тутамд гаргасан байх; *Сахилгын шийтгэлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх; *Мэдээллийг тухай бүр шинэчилж иргэд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байх;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.6 дугаар арга хэмжээ- Мөрдөгчийн мэдээгдэл, зөрчил арилгуулах шаардлагын мөрөөр ажиллах;				
	Төлөвлөлтийн уялдаа:	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн			
	Суурь түвшин	2020 онд нийт 11 байгууллагад 18 мэдээгдлийн мөрөөр ажиллаж, үр дүнг тооцсон.			
	Шалгуур үзүүлэлт	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан “Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх” үүргийн гүйцэтгэлийг хангууласан эсэхийг хянаж, шаардлагатаа арга хэмжээ авсан байх;			
	Хүрэх түвшин	Жилдээ: Мөрдөгчийн мэдээгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр газар дээр нь ажилласнаар авлигын гэмт хэрэг, зөрчил гарах болсон шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг арилгах, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлнэ.			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.7 дугаар арга хэмжээ- Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний 2021 оны судалгааг төрийн үйлчилгээ авсан иргэдийн дунд зохион байгуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэх;				
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 Авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх; АТҮХ-ийн 4.1.1, АТҮХ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.2.5			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал
	Шаардагдах хөрөнгө	60.000.0			
	Хариуцах нэгж	Судалгаа, шинжилгээний алба, Ахлах комиссар Ц.Шинэбаяр			
	Суурь түвшин	*Жил бүр үнэлгээг хийж, олон нийтэд мэдээлдэг.			
	Шалгуур үзүүлэлт	*Ажлын даалгавар тодорхой болсон байх; *Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх; *Үнэлгээний тайланг хүлээн авсан байх;			
	Хүрэх түвшин	*Үнэлгээ хийгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн байна. *Үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал танилцуулагдаж, холбогдох бусад арга хэмжээ авагдсан байх;			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
---	--	--	--	--	--

Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.8 дугаар арга хэмжээ: Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 зүйл				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-улирал
	Шаардагдах хөрөнгө	9.900 сая төгрөг				
	Хариуцах нэгж	Судалгаа, шинжилгээний алба, Ахлах комиссар Ц.Шинэбаяр				
	Суурь түвшин	*Жил бүр төсөөллийн судалгааг хийж, олон нийтэд мэдээлдэг. *Судалгааг “Хүлүгү санаачлага” НҮТББ гүйцэтгэж тайланг хүлээлгэн өгөв. Судалгааны явцад эхлэлтийн болон явцын тайланг хүлээн авч танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллав.				
	Шалгуур үзүүлэлт	*Ажлын даалгавар тодорхой болсон байх; *Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх; *Үнэлгээний тайланг хүлээн авсан байх.				
	Хүрэх түвшин	*Судалгааны тайланг хүлээн авсан байх; *Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.9 дүгээр арга хэмжээ- Шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн судалгааг зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 зүйл				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-улирал
	Шаардагдах хөрөнгө	9.900 сая төгрөг				
	Хариуцах нэгж	Судалгаа, шинжилгээний алба, Ахлах комиссар Ц.Шинэбаяр				
	Суурь түвшин	*Жил бүр судалгааг хийж олон нийтэд танилцуулдаг.				
	Шалгуур үзүүлэлт	*Ажлын даалгавар хийгдсэн байх; *Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх; *Үнэлгээний тайланг хүлээн авсан байх.				
	Хүрэх түвшин	*Судалгааны тайланг хүлээн авсан байх; *Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.10 дугаар арга хэмжээ- Авлигын эрсдэлийн үнэлгээг хийх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Судалгаа, шинжилгээний алба, Ахлах комиссар Ц.Шинэбаяр				
	Суурь түвшин	2020 оны сүүлийн хагас жилд Авлигын эрсдэлийн үнэлгээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сан зэрэг байгууллагуудыг хамруулав. Үнэлгээг хийлгэхээр “Эм Эм Си Жи” ХХК, “Онч шийдэл” ТББ-ыг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, эхлэлтийн, явцын тайланг хүлээн аваад байна.				
	Шалгуур үзүүлэлт	* Үнэлгээ хийх хүрээг тогтоож, ажлын даалгавар хийгдсэн байх; *Үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх; *Үнэлгээний тайланг хүлээн авсан байх.				
	Хүрэх түвшин	*Судалгааны тайланг хүлээн авсан байх; *Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
---	--

Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.11 дүгээр арга хэмжээ- Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах (6 төрлийн судалгаа зохион байгуулах)					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	63.000.0				
	Хариуцах нэгж	Судалгаа, шинжилгээний алба, Ахлах комиссар Ц.Шинэбаяр, УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	*Энэ төрлийн зорилтот судалгаа хийгдэж байгаагүй.				
	Шалгуур үзүүлэлт	*Судалгааны ажлын даалгавар боловсрогдсон байх; *Судалгааны багийг сонгон шалгаруулсан байх; *Ажлын тайланг хүлээн авч, зөвлөмжийг боловсруулж талуудад хүргүүлсэн байх; *Судалгаа хийгдэж, цаашид авах арга хэмжээний санал, ажлын чиглэл тодорхой болсон байх;				
	Хүрэх түвшин	*Төрийн байгууллагаас 2019. 2020 онд зарласан худалдан авах ажиллагаан дахь авлигын нөхцөл байдлын судалгаа , *Ажилгүй болон амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой иргэдийн дундах авлигын төсөөллийн судалгаа, *Гаалийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын төсөөллийн судалгаа *Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын төсөөллийн судалгаа; *Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны талаарх судалгаа; *Сонгуулийн санхүүжилтийн талаарх судалгаа; *Авлигын нөхцөл байдлын системийн динамик загварчлал боловсруулах				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.12 дугаар арга хэмжээ-“Шударга ёс” онол-арга зүйн цуврал сэтгүүлийг эмхлэн гаргах				
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18.1.5			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Байгууллагын төсөвт тусгасан.			
	Хариуцах ажилтан	Судалгаа, шинжилгээний алба, Ахлах комиссар Ц.Шинэбаяр			
	Суурь түвшин	*“Шударга ёс” онол, арга зүйн цувралын 2020 оны эхний дугаарыг 07 дугаар сард эмхэтгэн хэвлүүлсэн. 2 дахь дугаарт хэвлүүлэх нийтлэлийг бэлэн болгоод байна.			
	Шалгуур үзүүлэлт	*Сэтгүүлд хэвлүүлэх баримт материалыг төвлөрүүлсэн байх; *Редакцийн зөвлөлөөр хэлэлцэж сонгож хэвлүүлсэн байх; *Түгээлт хийсэн байх;			
	Хүрэх түвшин	2020 оны 05, 10 дугаар сард тус бүр 1 дугаарыг эмхлэн хэвлүүлж түгээсэн байна.			

Гүйцэтгэлийн зорилт № 2.2 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, ХАСУМ-ийг хянах, төлөвлөгөөт болон иргэн, аж ахуйн нэгж бйгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэлийн зорилт № 2.2.1. Улсын хэмжээнд мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж арга зүйн удирдлагаар ханган ажиллах, бүртгэл, дүн мэдээг нэгтгэн боловсруулж, олон нийтэд мэдээлэх;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.1 дүгээр арга хэмжээ- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид ХАСХОМ гэх/-ийг шинэчлэн бүртгэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, мэдээлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3, 11.4, 18.4.13, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 28 дугаар зүйлийн 28.10, НАНБХАСЗАСЗУСХ-ийн 23.3, 24.1.1, 24.2				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс. Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар				

	Суурь түвшин	*Төрийн захиргааны болон нутгийн захиргааны 110 байгууллага тэдгээрийн салбар нэгжийн 1766 эрх бүхий албан тушаалтнуудыг мэдээлэл арга зүйгээр хангаж, цахим системийн үйл ажиллагаанд хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. *ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2020 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт 41686 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 41385 мэдүүлэг гаргагч мэдүүлж, 1 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй буюу гаргахаас татгалзсан дүн гарсан.
	Шалгуур үзүүлэлт	*Албан тушаалтнуудын 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн байна. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, мэдээлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, мэдээлэл арга зүйгээр хангах, хуулийн хэрэгжилтийг хангасан байна.
	Хүрэх түвшин	*Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудаас Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг гаргуулан авах, хянасан байна. *АТГ-т мэдүүлгээ гаргадаг төрийн өндөр албан тушаалтны нэгдсэн судалгааг гаргаж, шилжилт хөдөлгөөн болон цахим системд хяналт тавих хуваарийг шинэчилсэн байна. *Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах, хугацаа сануулсан, мөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг сурталчилсан шторкийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, сурталчилсан байна. *Төрийн захиргааны төв, орон нутгийн нийт 117 байгууллагын мэдүүлэг гаргагч албан тушаалтан болон тэдгээрийн салбар нэгжийн 1704 эрх бүхий албан тушаалтнуудад сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр хангасан байна. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх ажлыг хуульд заасан хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, бүртгэл, дүн мэдээг нэгтгэн боловсруулж, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.2 дугаар арга хэмжээ-ХАСХОМ гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээллийг хуулийн хугацаанд УИХ-ын ХЗБайнгын хороонд хүргүүлэх, ХОМ гаргах журмын биелэлтийн талаар олон нийтэд мэдээлэх, ҮАБЗ, Үндэсний статистикийн хороонд холбогдох мэдээ, тайланг хүргүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3, 14.5 18 дугаар кзүйлийн 18.4.13, 18.4.14, 18.4.15, НАНБХАСЗАСЗУСХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.3, 25 дугаар зүйлийн 25.1, 26.1, 26.7 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг, ҮСХ-ний 2019 оны А/89 тушаал.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар				
	Суурь түвшин	*ХАСХОМ-ийн цахим системд мэдүүлгээ бүртгүүлсэн Төрийн болон нутгийн захиргааны нийт 36832 албан тушаалтны 2019 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын http://www.xasxom.iaas.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээллээр хангасан. Жил бүр мэдээ, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж байгаа.				
	Шалгуур үзүүлэлт	*Төрийн албан хаагчдын болон сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, явц байдлын талаарх танилцуулга мэдээлэл бэлтгэн ҮАБЗ, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хуульд заасан хугацаанд хүргүүлсэн байх; *Нийтийн албан тушаалтны болон сонгуульд нэр дэвшигчдийн ХОМ-ийг нээлттэй мэдүүлэх техникийн боломжийг бүрдүүлсэн байх; *Нийтийн албан тушаалтнуудын 2020 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын http://www.xasxom.iaas.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан байх.				
	Хүрэх түвшин	*Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын 2020 оны ХАСХОМ-ын баталгааны маягтын эх хувийг холбогдох тайлан, бүртгэл, нэрсийн жагсаалтын хамт, 2020 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчилсэн бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээлэл, УИХ-ын болон бүх шатны ИТХ-ийн сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хороонд, "Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц				

		байдлын талаар” танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн байх; *Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 117 байгууллагаас ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн Үндэсний Статистикийн газарт хүргүүлж албан ёсны захиргааны статистикийг бүрдүүлсэн байх; *Улсын хэмжээнд ХАСХОМ мэдүүлсэн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр байгууллагын http://www.hasxom.iaac.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийт мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байх;
--	--	---

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.3 дугаар арга хэмжээ- Мэдүүлгийн цахим системийн хөгжүүлэлтийг тухай бүр хийх, цахим мэдээллийн баазыг ашиглан судалгаа дүн шинжилгээ хийж, хяналтыг сайжруулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3, 14.5, 18 дугаар зүйлийн 18.4.13, 18.4.15, НАНБХАСЗАСЗУСХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.3, 25 дугаар зүйлийн 25.1, 26.1, 26.7 Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн 4.1.5.13 4.1.5.14, 4.1.9.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	50,000.0 мян.төг				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар, АБХШНАлба, Ахлах комиссар Т.Энхболд				
	Суурь түвшин	*Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийг 2012 оноос ашиглаж ирсэн. *2016 онд тодорхой шинэчлэл хийгдсэн бөгөөд хөгжүүлэлт хийгдэх шаардлагатай. * Unitel ХХК-тай гэрээ байгуулан програмын хөгжүүлэлт хийхээр ажиллаж байна.				
	Шалгуур үзүүлэлт	*ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтны хамрах хүрээг оновчтой тогтоох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; /Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо мэдүүлдэг, тэдгээрийн мэдүүлсэн хөрөнгө, орлогын мэдээллийг олон нийтэд хүргэх арга зам тодорхойлогдсон байх; *Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт шинэчлэгдсэн үед, нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан системийг шинэчилэх, хөгжүүлэлтийг хийх; *Мэдүүлгийн төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд болон цахим системийг ашиглан мэдүүлэг гаргагчдын хөрөнгө, орлогын өсөлт бууралтад хяналт тавьж зөрчлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх;				
	Хүрэх түвшин	*Цахим сангийн мэдээлэлд үндэслэн албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт бууралтад дүн шинжилгээ хийж, зөрчил илрүүлэлтийн үзүүлэлт өссөн байна.				

Гүйцэтгэлийн зорилт № 2.2.2 **Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянаж, дүн шинжилгээ хийх;**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.2.1 дүгээр арга хэмжээ- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, мэдэгдэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	НАНБХАСЗАСЗУСХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар				
	Суурь түвшин	2019 онд Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 13151 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авч, 13030 этгээдийн мэдүүлгийг хянан үзэж, холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн. Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан 848, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 489 мэдүүлгийг буцаан хүргүүлсэн, 8 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хариу хүргүүлсэн.				
	Шалгуур үзүүлэлт	*Нийтийн албан тушаалтын ХАСУМ-ийг хуульд заасны дагуу хянасан байх; *ХАСУМ-д судалгаа, дүн шинжилгээ хийсэн байх;				
	Хүрэх түвшин	*Төрийн захиргааны төв болон орон нутгийн салбар нэгж байгууллагын хэмжээнд албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хянаж, тоон мэдээлэл, гарсан дүгнэлтэд судалгаа хийсэн байна. *Дүн шинжилгээг хийж, үнэлэлт дүгнэлт гаргах, дүгнэлтэд тулгуурлаж судалгаа хийх, Зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгасан байх, үр дүнг тооцсон байна.				

		*Төрийн албан хаагчийн улсын нээдсэн тоо бүртгэлийн системтэй ХАСУМ-ийн цахим системийг уялдулан холбох, хяналтын механизмыг сайжруулах, ТАЗ-тэй хамтран ажиллах;
--	--	---

Гүйцэтгэлийн зорилт № 2.2.3 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; /хориголто, хязгаарлалт, бусад/

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.3.1 дүгээр арга хэмжээ- Нийтийн албанд гарч байгаа авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, дүн шинжилгээ хийх, үр дүнг үйл ажиллагаанд ашиглах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 32 ¹ дүгээр зүйлийн 32 ¹ .1.2, 18 дугаар зүйлийн 18.4.14, 18.4.16 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар				
	Суурь түвшин	Мэдүүлгийн цахим систем ашиглан ЭМЯ, ХХААХҮЯ, БСШУСЯ, БХБЯ, ГХЯ, МХЕГ-ын нийт 57 албан тушаалтны сүүлийн 5 жилийн ХОМ-д мэдүүлсэн мэдээллийг бүртгэл хяналтын байгууллагын мэдээлэл, лавлагаатай тулган бүрдүүлэлтийн хяналтыг хэрэгжүүллээ. Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийн байдлыг хянах, хууль тогтоомж зөрчигдсөн эсэхийг судлан тогтоох зорилгоор Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 8 яамны нийт 1151 албан тушаалтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгаж, зөрчил гаргасан нь тогтоогдсон 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.1-д заасныг үндэслэн нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлттэй холбоотой асуудлыг судлан энэхүү асуудлыг нэг мөр зохицуулах, Засгийн газраас холбогдох журмын төслийг боловсруулж ажиллах талаар ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргад саналыг хүргүүлсэн.				
	Шалгуур үзүүлэлт	“Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн зөрчлүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоосон байна. *Холбогдох арга хэмжээ авсан байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд -Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид төрийн захиргааны албанд томилогдож байгаа явдалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авсан байх; Сүүлийн хагас жилд -Нийтийн албан тушаалтнууд хуульд заасан хориголто, хязгаарлалтыг мөрдөж ажиллаж байгааг шалгаж, холбогдох арга хэмжээ авсан байна.				

Гүйцэтгэлийн зорилт № 2.2.4 Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, тэдний үр чадварыг нэмэгдүүлэх;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.4.1 дүгээр арга хэмжээ- Төрийн захиргааны болон орон нутгийн салбар, нэгжийн мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.14, 18.4.16, УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 05 дугаар тогтоолын “Гурав” дахь хэсэг				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар				
	Суурь түвшин	*Төрийн болон нутгийн захиргааны төв болон салбар байгууллагын 1766 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны судалгааг шинэчлэн гаргасан. *Төрийн захиргааны төв байгууллага болох яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтнуудын сургалтыг зохион байгуулж, ном, гарын авалагаар хангасан.				
	Шалгуур үзүүлэлт	*ЭБАТ-ны судалгааг шинэчилэн гаргасан байх;				

		<i>*Шинээр томилогдсон ЭБАТ-ыг сургалтад хамруулж, мэдлэг олгох, ур чадварын түвшинг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, сургалтад хамруулсан байх;</i>
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд *ЭБАТ-ын судалгаа шинэчилэгдэж, ХАСХОМ бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах ажиллагаа хуульд заасны дагуу явагдах нөхцөл бүрдсэн байна. *Сургалт зохион байгуулсан байх; *Гарын авлагыг шинэчилж, түгээлт хийсэн байх;
		2-4 дүгээр улиралд *Сургалт зохион байгуулсан байх; *Мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол хангасан байх;

Гүйцэтгэлийн зорилт № 2.2.5 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллаас ирүүлсэн Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.5.1 дүгээр арга хэмжээ- Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч хянан шалгах, үр дүнг тооцох;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 7,9, 13 дугаар зүйлийн 13.5, 18.4.16, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар				
	Суурь түвшин	2020 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 656, өмнөх оны үлдээдэл 48, нийт 704 гомдол, мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 616-г хянан шийдвэрлэсэн, 40 гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, 36 нэгжээр буюу 5.2 хувиар, хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл 78 нэгжээр буюу 11.3 хувиар буурсан, шийдвэрлэлт 87.5 хувьтай байна. Хянан шалгасан гомдол, мэдээллээс 73 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, үүнээс 25 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, давхардсан тоогоор 64 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн. Хуульд заасан үндэслэлээр буцаасан 31, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэх үндэслэлээр шилжүүлсэн 116, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 128, гомдлоо буцаасан 51, зөрчил илрээгүй 263 байна.				
	Шалгуур үзүүлэлт	*Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгасан байх; *Шийдвэрлэлтийн хувь өссөн байх. *Зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэсэн талаарх мэдээллийг өөрийнх нь зардлаар олон нийтэд мэдээлэх, түүнчлэн зөрчлийн шалтгаан нөхцөл, хор уршгийг арилгах чиглэлд УССГХ-тай хамтран ажилласан байх; *Авлигын гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд шалгуулахаар эрх бүхий нэгжид шилжүүлэх, бусад хэлтэстэй хамтран ажилласан байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтад чанарын ахиц гарч, шийдвэрлэлтийн хувь өмнөх оны мөн үеэс өссөн байна. *Шийдвэрлэх хугацаа сунгах тохиолдлыг 30 хувь бууруулж, анхны хугацааны шийдвэрлэлт өссөн байна. *Өргөдөл, гомдол, мэдээлэл болон шийдвэрлэлтэд судалгаа, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авсан байх; Сүүлийн хагас жилд: *Өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтад чанарын ахиц гарч, шийдвэрлэлтийн хувь өмнөх оны мөн үеэс өссөн байна. *Шийдвэрлэх хугацаа сунгах тохиолдлыг 30 хувь бууруулж, анхны хугацааны шийдвэрлэлт өссөн байна. *Өргөдөл, гомдол, мэдээлэл болон шийдвэрлэлтэд судалгаа, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авсан байх;				

Гүйцэтгэлийн зорилт № 2.3 Авлигын эсрэг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.1 дүгээр арга хэмжээ- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрэн шалгаж, шийдвэрлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн				

	Суурь түвшин	Гэмт хэргийн шинжтэй 1020 гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэж, 281 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл өмнөх оны мөн үеэс 126 нэгжээр буюу 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүлээн авч шалгасан 1020 гомдол, мэдээллээс 462 гомдол, мэдээлэл буюу 45.3 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээх, 487 гомдол, мэдээлэл буюу 47.7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 27 гомдол, мэдээлэл буюу 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 44 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 95.7 хувьтай байна. /99.1/
	Шалгуур үзүүлэлт	*Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг бүрэн хүлээн авч, бүртгэсэн байх; *Гомдол, мэдээллийг байгууллагын цахим сан болон прокурорын хяналтад оруулсан байх; *Гомдол, мэдээллийн тоо мэдээ үнэн зөв гарсан байх;
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Гомдол мэдээллийн шийдвэрлэлт 97.2 хувьд хүрсэн байна. Сүүлийн хагас жилд: Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь өссөн байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.2 дугаар арга хэмжээ- Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.11				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгаах хэлтэс, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн				
	Суурь түвшин	Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй буюу авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 10 үйлдлийг шалгуулахаар харьяалах хэлтэст шилжүүлж хянан шалгах боломжийг бүрдүүлэв. Тайлант хугацаанд шалгасан нийт мэдүүлгийн 60 буюу 10.3 хувийг МШХ, ГАХ-ээс шилжүүлснээр шалгасан байна.				
	Шалгуур үзүүлэлт	*Тухай бүр холбогдох мэдээллийг холбогдох хэлтэст шилжүүлсэн байх; *Энэ тухай бүртгэл хөтлөгдсөн байх; *Улирал тутамд дүн гаргасан байх; *Хэлтэс, албадын хамтын ажиллагааг хангасан байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүртгэл судалгаатай болсон байна. Сүүлийн хагас жилд: Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүртгэл судалгаатай болсон байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.3 дугаар арга хэмжээ- Мөрдөн шалгах ажиллагааг хуулийн дагуу шуурхай явуулж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт хэргийн 64.0 хувийг шийдвэрлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.7, 18.5, 18.6, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төсөвт тусгагдсан зардал				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн				
	Суурь түвшин	Авлигын гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеэс 23,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнө оны мөн үетэй харьцуулбал, 2.4 хувийн өсөлттэй байна. /2019 онд 1300 хэрэг/. Нийт шалгасан хэргийн 236 буюу 17.7 /2019 онд 156 буюу 12.0 хувь/ шүүхэд шилжүүлэх саналтай, 509 буюу 38.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай саналтай, 48 буюу 3.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 46 хэргийг нэгтгэн шалгаж, 6 хэргийг түдгэлзүүлж, одоо 486 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 426 хэрэг, мөрдөн байцаалтын 60 хэрэг байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 63.5 хувьтай буюу өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1330 хэрэгээс шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2019 онтой харьцуулбал, 5.7 пунктээр өссөн байна.				

	Шалгуур үзүүлэлт	*Мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийсэн байх; *Шийдвэрлэх хэргийн графикийн биелэлтийг тухай бүр гаргасан байх; *Хавтаст хэргийн болон хэргийн шийдвэрлэлтийн график хоцорсон, удааширч байгаа хэрэгтэй материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилга өгч, биелэлтийг хангуулах; *Шийдвэрлэх хэргийн график гаргаж, прокурорын байгууллагатай хамтран баталсан байх; *Мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн мөрдөгчид даалгасан байх; *Шаардлагатай гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэж хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх; *шаардлагатай тохиолдолд мөрдөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлсэн байх;
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үеэс ахиулсан байна. Сүүлийн хагас жилд: Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 64.0 хувьд хүрсэн байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.4 дүгээр арга хэмжээ- Мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй, чанартай гүйцэтгэж, нотлох баримт дутуу, хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлээгүй гэх үндэслэлээр прокурор, шүүхээс эрүүгийн хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар буцсан хэрэг өмнөх оны мөн үеэс 5 хувиар бууруулах;				
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.7, 18.5, 18.6, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "Мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй."			
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-			
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, Эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн			
	Суурь түвшин	2020 онд нийт 1331 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас шүүх, прокуророос давхардсан тоогоор 328 хэрэг буюу 24.6 хувь нь нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр буцсан байна. Өмнөх онтой харьцуулахад прокурорын буцалт 55-аар буюу 21.8 хувиар өсч, шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэг 21-ээр буюу 48.8 хувиар буурч шалгуур үзүүлэлтийг хангасан дүнтэй байна. Эрүүгийн хэрэг прокурор, шүүхээс буцахгүй байхад анхаарч, олон үйлдэлтэй, ажиллагаа ихтэй, шүүх, прокуророос буцсан эрүүгийн хэрэгтэй хэлтэс, албадын дарга нар биечлэн танилцаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт заасны дагуу мөрдөгчдөд 67 удаа бичгээр зааварчилга өгч, хугацаа тогтоон биелэлтийг нь хангуулж ажилласан. Нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэгт бүртгэлээр хяналт тавьж, буцсан шалтгаан, нөхцөлийг тогтоон шаардлагатай ажиллагаануудыг тухай бүр хийсэн. Мөн шүүх, прокуророос буцсан хэргийн шалтгааныг тогтоож, үндэслэлгүй тогтоол, бичигдсэн прокурорын даалгаварт тухай бүр санал бичих, нэмэлт ажиллагаа хийх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.			
	Шалгуур үзүүлэлт	*Шүүх, Прокуророос буцсан хэргийн бүртгэл хөтлөгдсөн байх; *Шүүх, Прокуророос буцсан хэргийн хувь буурсан байх; *Хэргийн буцсан үндэслэлд дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулсан байх.			
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Шүүх, прокурорын байгууллагаас нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэгт бүртгэлээр хяналт тавьж, буцсан шалтгаан, нөхцөлийг тогтоосон байна. *Шүүх, прокуророос буцсан хэргийн шалтгааныг тогтоож, үндэслэлгүй тогтоолд тухай бүр санал бичих, нэмэлт ажиллагаа хийх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна. *Шүүх, прокуророос буцсан хэргийн тоо, шилжүүлсэн хэрэгт эзлэх хувь буурсан байна. Сүүлийн хагас жилд: *Шүүх, прокурорын байгууллагаас нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэгт бүртгэлээр хяналт тавьж, буцсан шалтгаан, нөхцөлийг тогтоосон байна. *Шүүх, прокуророос буцсан хэргийн шалтгааныг тогтоож, үндэслэлгүй тогтоолд тухай бүр санал бичих, нэмэлт ажиллагаа хийх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна. *Шүүх, прокуророос буцсан хэргийн тоо, шилжүүлсэн хэрэгт эзлэх хувь буурч 30.0 хувьд хүрсэн байна.			

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.5 дугаар арга хэмжээ-Шүүхэд шилжүүлсэн, шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.7, 18.5, 18.6, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, бусад холбогдох хэсэг.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн				
	Суурь түвшин	2020 онд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнө оны мөн үетэй харьцуулбал, 2.4 хувийн өсөлттэй байна. /2019 онд 1300 хэрэг/. 2019 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1300 хэргээс 156 буюу 12.0 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж байсан бол 2020 онд 1331 хэргээс 236 хэргийг буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 5.7 пунктээр өссөн байна. 2020 онд нийт 845 хэрэг шийдвэрлэсний 236 буюу 27.9 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлж шийдвэрлэсэн. 2019 онд тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулан шүүхэд шилжүүлсэн хэргээс 68 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2020 онд 114 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оны мөн үеэс 67.6 хувиар өссөн.				
	Шалгуур үзүүлэлт	Хэргийн нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоож, шүүхэд шилжүүлсэн болон шийдвэрлэгдсэн хэргийн хувь өссөн байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Өмнөх оны мөн үеэс ахисан байна. Сүүлийн хагас жилд: Шийдвэрлэсэн хэргийн дотор шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн эзлэх хувь өссөн байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.6 дугаар арга хэмжээ-Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, олсон орлого, нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгийг битүүмжлэн хамгаалах арга хэмжээг авч хохирол нөхөн төлүүлэлтийг урьд оны мөн үеэс нэмэгдүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.7, 18.5, 18.6, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, бусад холбогдох хэсэг.				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн				
	Суурь түвшин	2020 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 12,133,529,9 сая /арван хоёр их наяд, нэг зуун гучин гурван тэрбум, таван зуун хорин есөн сая, есөн зуун мянга/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 35,640,6 сая /гучин таван тэрбум, зургаан зуун дөчин сая, зургаан зуун мянга/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 10,112,736,4 сая /арван их наяд, нэг зуун арван хоёр тэрбум, долоон зуун гучин зургаан сая, дөрвөн зуун мянга/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.				
	Шалгуур үзүүлэлт	*Мөрдөн байцаалтын хэрэгт бүрт учирсан хохирлыг бүрэн тогтоосон байх *Хохирол учирсан байгууллага, иргэнийг хохирогч иргэний нэхэмжлэгчээр тогтоож мэдүүлэг авсан байх; *Хэрэг бүрт хөрөнгө хамгаалах, хязгаарлах битүүмжлэх ажиллагааг хийсэн байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг 5.0 хувиар ахиулсан байна. Сүүлийн хагас жилд: Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг 5,0 хувиар ахиулсан байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.7 дугаар арга хэмжээ-Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичих, үр дүнг тооцох чиглэлээр УССГХ-тэй хамтран ажиллах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.7, 18.5, 18.6, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 29.6 дугаар зүйл				

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн, УССГХ, Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн				
	Суурь түвшин	Авлига албан тушаалын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг судлан яамдын харьяа байгууллагууддаа болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шат шатны удирдлагын болон дотоод хяналт сул, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх журмын хэрэгжилт хангадаггүй, хүний нөөцийн томилгоо хууль тогтоомжид нийцээгүй, сул орон тоог нээлттэй зарладаггүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилладаггүй, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага хангаагүй мэргэжлийн бус хүнийг ажлын байранд томилдог зэрэг нийтлэг зөрчлүүд тогтоогдсон тул гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2020 онд эрх бүхий албан тушаалтанд мөрдөгчийн 103 мэдэгдэл бичсэн. Одоогоор 65 /63.1/ мэдэгдлийн хариуг хүлээн аваад байна. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулахаар 43 албан бичгийг хүргүүлэн 35 /81.4/ хариу авсан. Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 61.8 хувьд мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичиг бичсэн үзүүлэлттэй байна. Нийт 18 мэдэгдлийн мөрөөр 11 байгууллагад ажиллаж, гүйцэтгэсэн ажил, арга хэмжээтэй танилцан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр зөвлөмж хүргүүлэв. Тухайлбал, ЗГХЭГ, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сум, ЦЕГ-ын МБА, Сонгинохайрхан, Налайх, Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтэс, ГХЯ-д тус тус ажиллаж, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэв.				
	Шалгуур үзүүлэлт	*Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 50-иас дээш хувьд нь гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байх; *Үр дүнг УССГХ-тэй хамтран тооцсон байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Мэдэгдлийн тоо өссөн байх; *Мэдэгдлийн хариуг мэдэгдэл хүргүүлсэн хуулийн этгээдээс 100 хувь хүлээн авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх; Сүүлийн хагас жилд: Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 50-иас дээш хувьд нь мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байх; *Мэдэгдлийн хариуг мэдэгдэл хүргүүлсэн хуулийн этгээдээс 100 хувь хүлээн авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх;				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.8 дугаар арга хэмжээ-Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн тоо бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, шаардлагатай тайлан мэдээг гаргах, дүн шинжилгээ хийх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Статистикийн тухай хуульд зааснаар Үндэсний статистикийн хорооны 2019 оны А/189 дүгээр тушаалаар олгосон зөвшөөрөл, АТГ-ын даргын 2020 оны А/02 дугаар тушаалаар баталсан АТГ-т бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн журам, маягт, заавар				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Мөрдөн шалгах хэлтэс, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн				
	Суурь түвшин	2020.01.01-ний өдрөөс шинэ цахим санг үйл ажиллагаанд нэвтрүүлсэнтэй холбогдуулан батлагдсан маягтын дагуу гомдол мэдээлэл, гэмт хэргийн тоо үзүүлэлтийг тухай бүр гаргаж улсын нэгдсэн статистикийг бүрдүүлэхийн зэрэгцээ албан хаагчдын үйл ажиллагаанд цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Албан хаагчдад цахим санд ажиллах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийг тухай бүр цахимаар танилцах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. 7 хоног тутамд хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч байна.				
	Шалгуур үзүүлэлт	*Цахим санд гомдол, мэдээллийн үнэн зөв, бүрэн оруулсан байх; *Тогтоосон хугацаанд цахим сангаар дамжуулан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэргийн тайлан, мэдээг гаргаж, ҮСХ-д хүргүүлсэн байх; *Мэдээ, тайланд үндэслэн сар тутамд танилцуулга, мэдээлэл бэлтгэгдэж танилцуулагдсан байх; *Мөрдөгчид санд мэдээллийг оруулах мэдлэг, чадвартай болсон байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Санд мэдээллийг бүрэн оруулж, статистик мэдээ бүрэн гарах нөхцөлийг хангасан байх; *Тогтоосон хугацаанд тайлан мэдээг гаргаж, зохих журмын дагуу ҮСХ болон эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байх; Сүүлийн хагас жилд: *Санд мэдээллийг бүрэн оруулж, статистик мэдээ бүрэн гарах нөхцөлийг хангасан байх; *Санд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн шаардлагатай мэдээ, судалгаа гардаг болсон байх;				

**ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭХ ҮР ДҮН**

Гүйцэтгэлийн зорилт №2.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэлийн зорилт № 2.1.1. Авлигын эсрэг хуульд заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулах зохицуулах, арга зүйн удирдлагаар хангах.

Гүйцэтгэлийн зорилт №2.1 Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилт, чиг үүргийн хэрэгжилт хангагдана.					
№	Үр дүнгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт	
			2020 он	Эхний хагас жил	Жилийн эцэс
1.	2.1.1.1.Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах	Хяналт-шинжилгээ, үнэлгээ	-	*Төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх талаар араг зүйн удирдлагаар хангах *Төрийн байгууллагуудаас явцын тайлан авч, дүн шинжилгээ хийх;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх; Тайланд дүн шинжилгээ хийх
2.	2.1.1.2. Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, иргэний санал, санаачилгыг дэмжин туслах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах	Гэрээний тоо	26 ТББ, 11 иргэн, 1 төрийн өмчит судалгааны байгууллага, 87 компанитай гэрээ байгуулж, ажилласан.	Фокус ярилцлага 10, гэрээ-5	Гэрээ-5, Хамтран ажилласан иргэд, ТББ-ын жагсаалт, зарцуулсан төсөв, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайлан-1
3.	2.1.1.3. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, авлигад өртөх боломжийг багасгах талаар Зөвлөмж боловсруулах	Зөвлөмжийн тоо	Нийт 20 зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.	*Хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн байх; *Ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн байх; *Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.	Зөвлөмжийн биелэлтийг тооцсон байна.
4.	2.1.1.4. Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах, ёс зүйн дүрмийн төсөлд санал өгөх	Саналын тоо Хүчингүй болгосон шийдвэрийн тоо	Нийт 18 дүрэм, журам, шийдвэрийг хянасан.	<i>Салбарт тус бүрт хамаарах 2-оос доошгүй дүрэм, журам, шийдвэрийг хянан үзэж, үр дүнг танилцуулсан байна. act.iaas.mn цахим бүртгэлийн системд оруулсан байна.</i>	
5.	2.1.1.5. Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг хэрэгжилтийг хангах, сан хөтлөх	Санд бүртгэгдсэн хүний тоо	25	*Сахилгын шийтгэлийн цахим дэд санд мэдээлэл байршуулах ажлыг зохион байгуулах, шинээр ирсэн бичгийг хүлээн авч бүртгэлд тухай бүр байршуулж, албан бичгийн мөрөөр ажиллаж байгаа мэдээ, илтгэх хуудсыг нэгтгэж, тоо мэдээг улирал тутамд гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх; *Мэдээллийг тухай бүр шинэчилж иргэд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байх;	
6.	2.1.1.6. Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах мэдэгдлийн мөрөөр ажиллах	Тайлангийн тоо	18	Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр газар дээр нь ажиллаж, үр дүнг тооцсон байх;	

7.	2.1.1.7 Шударга байдлын үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан	1	-	1
8.	2.1.1.8 Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг зохион байгуулах;	Судалгааны тайлан	1	-	1
9.	2.1.1.9 Шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн судалгааг зохион байгуулах;	Судалгааны тайлан	1	-	1
10.	2.1.1.10 Авлигын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх;	Үнэлгээний тайлан	1	-	1
11.	2.1.1.11 Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлах (6 төрлийн судалгаа зохион байгуулах)	Үнэлгээний тайлан	-	Зорилтот судлагнааны ажлыг бусдаар гүйцэтгүүлж; тайланг үндэслэн зөвлөмж боловсруулсан байх;	УССГ ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
12.	2.1.1.12 Шударга ёс онол, арга зүйн сэтгүүлийг эрхлэн хэвлүүлэх	Дугаар	-	1	1

Гүйцэтгэлийн зорилт № 2.2 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, ХАСУМ-ийг хянах, төлөвлөгөөт болон иргэн, аж ахуйн нэгж бйгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

11.	2.2.1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэх, Монгол Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, мэдээлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	ХАСХОМ мэдүүлсэн албан тушаалтны тоо	Улсын хэмжээнд Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 41686 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 41385 мэдүүлэг гаргагч мэдүүлж, 1 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй буюу гаргахаас татгалзсан дүн гарсан. /99.9%/	Улсын хэмжээнд мэдүүлэг гаргавал зохих албан хаагчид 100 хувь мэдүүлгээ мэдүүлсэн байна.	*
12	2.2.1.2 ХАСХОМ гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээллийг хуулийн хугацаанд УИХ-ын ХЗБайнгын хороонд хүргүүлэх, ХОМ гаргах журмын биелэлтийн талаар олон нийтэд мэдээлэх, УАБЗ, Үндэсний статистикийн хороонд холбогдох мэдээ, тайланг хүргүүлэх;	Хуулийн хугацаанд ил тод болгож, мэдээ, тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байх;	ХАСХОМ-ийн цахим системд мэдүүлгээ бүртгүүлсэн Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтны 2019 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын http://www.xasxom.iaac.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, мэдээллээр хангсан. Жил бүр мэдээ, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж байгаа.	Хуулийн хугацаанд мээ тайланг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна. Мөн ХАСХОМ-ийн хураангуй мэдээллийг цахим санд хугацаанд нь байршуулж, олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн байна.	*

13	2.2.1.3 Мэдүүлгийн цахим системийн хөгжүүлэлтийг тухай бүр хийх, цахим мэдээллийн баазыг ашиглан судалгаа дүн шинжилгээ хийж, хяналтыг сайжруулах	Хянагдсан ХАСХОМ-ийн тоо	*Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийг 2012 оноос ашиглаж ирсэн. *2016 онд тодорхой шинэчлэл хийгдсэн, хөгжүүлэлт хийгдэх шаардлагатай. * Unitel ХХК-тай гэрээ байгуулан програмын хөгжүүлэлт хийхээр ажиллаж байна.	*Цахим сангийн мэдээлэлд үндэслэн албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт бууралтад бүрэн дүн шинжилгээ хийж, зөрчил илрүүлэлтийн үзүүлэлт өссөн байна.	*Цахим сангийн мэдээлэлд үндэслэн албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт бууралтад бүрэн дүн шинжилгээ хийж, зөрчил илрүүлэлтийн үзүүлэлт өссөн байна.
14	2.2.2.1 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, мэдэгдэх;	Хянагдсан ХАСУМ-ийн тоо	2019 онд Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 13151 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авч, 13030 этгээдийн мэдүүлгийг хянасан. Анхааруулсан 848, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр буцаасан 489, 8 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Төрийн захиргааны төв болон орон нутгийн салбар нэгж байгууллагын хэмжээнд албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хянаж, тоон мэдээлэл, гарсан дүгнэлтэнд судалгаа хийсэн байна. *Дүн шинжилгээг хийж, үнэлэлт дүгнэлт гаргах, дүгнэлтэд тулгуурлаж Зөвлөмж өгч, үр дүнг тооцсон байна.	Төрийн захиргааны төв болон орон нутгийн салбар нэгж байгууллагын хэмжээнд албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хянаж, тоон мэдээлэл, гарсан дүгнэлтэнд судалгаа хийсэн байна. *Дүн шинжилгээг хийж, үнэлэлт дүгнэлт гаргах, Зөвлөмж өгч, үр дүнг тооцсон байна.
15.	2.2.3.1 Нийтийн албанд гарч байгаа авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцлийг тогтоож, дүн шинжилгээ хийх, үр дүнг үйл ажиллагаанд ашиглах;	Үйл ажиллагааны хүрээ	Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийн байдлыг хянах, хууль тогтоомж зөрчих асуудал байгаа эсэхийг судлан тогтоох үйл ажиллагааны хүрээнд төрийн бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулж, зөрчлийг арилгасан.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид төрийн захиргааны албан томилогдож байгаа явдалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авсан байх;	Нийтийн албан тушаалтнууд хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллаж байгааг шалгаж, холбогдох арга хэмжээ авсан байна.
16.	2.2.4.1 Төрийн захиргааны болон орон нутгийн салбар, нэгжийн мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах;	ЭБАТ-ын судалгаа, сургалтын тоо	Төрийн болон нутгийн захиргааны төв болон салбар байгууллагын 1766 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны судалгааг шинэчлэн гаргасан.	*ЭБАТ-ын судалгаа шинэчилэгдэж, ХАСХОМ бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах ажиллагаа хуульд заасны дагуу явагдах нөхцөл бүрдсэн байна. *Сургалт зохион баагуулсан байх; *Гарын авлагыг шинэчилж, түгээлт хийсэн байх;	*Сургалт зохион байгуулсан байх; *Мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол хангасан байх;
17.	2.2.5.1 Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч хянан шалгах, үр дүнг тооцох;	хувь	2020 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 656, өмнөх оны үлдэгдэл 48, нийт 704 гомдол,	Шийдвэрлэлтийн хувь өмнөх оны мөн үеэс өссөн байна. *Шийдвэрлэх хугацаа сунгах тохиолдлыг 30 хувь буурсан байна.	Шийдвэрлэлтийн хувь өмнөх оны мөн үеэс өссөн байна. *Шийдвэрлэх хугацаа сунгах тохиолдлыг 30

			мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 616-г хянан шийдвэрлэсэн, 40 гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байсан.		хувь буурсан байна.
Гүйцэтгэлийн зорилт № 2.3 Авлигын эсрэг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;					
1.	2.3.1.1 Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, хуульд заасан үндэслэл журмын дагуу бүрэн шалгаж, шийдвэрлэх;.	Хувь	2019 онд гэмт хэргийн шинжтэй 1020 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт 95.7 хувьтай байна.	Гомдол мэдээллийн шийдвэрлэлт 97.2 хувьд хүрсэн байна.	Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь өссөн байна.
2.	2.3.1.2 Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;	тоо	Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 10 үйлдлийг шалгуулахаар харьяалах хэлтэст шилжүүлсэн. Шалгасан нийт мэдүүлгийн 60 буюу 10.3 хувийг МШХ, ГАХ-ээс шилжүүлснээр шалгасан байна.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүртгэл судалгаатай болсон байна.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. Хуулийн хэрэгжилт хангагдаж, бүртгэл судалгаатай болсон байна.
3.	2.3.1.3 Мөрдөн шалгах ажиллагааг хуулийн дагуу шуурхай явуулж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт хэргийн 64.0 хувийг шийдвэрлэх;	Хувь	<i>Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнө оны мөн үетэй харьцуулбал, 2.4 хувийн өсөлттэй байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 63.5 хувьтай буюу өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</i>	Эхний хагас жилд: Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үеэс ахиулсан байна.	Сүүлийн хагас жилд: Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 64.0 хувьд хүрсэн байна. байх;
4.	2.3.1.4 Мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй, чанартай гүйцэтгэж, нотлох баримт дутуу, хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлээгүй гэх үндэслэлээр прокурор, шүүхээс эрүүгийн хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар буцсан хэрэг өмнөх оны мөн үеэс бууруулах;	хувь	Өмнөх онтой харьцуулахад прокурорын буцалт 55-аар буюу 21.8 хувиар өсч, шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэг 21-ээр буюу 48.8 хувиар буурсан байна.	Прокурор, шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан хэрэг өмнөх оны мөн үеэс буурсан байх;	Шүүх, прокуророос буцсан хэргийн тоо, шилжүүлсэн хэрэгт эзлэх хувь буурч 30.0 хувьд хүрсэн байна.
5.	2.3.1.5 Шүүхэд шилжүүлсэн, шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх;.	хувь	2020 онд 1331 хэргээс 236 хэргийг буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай	Өмнөх оны мөн үеэс ахисан байна.	Өмнөх оны мөн үеэс ахисан байна.

			прокурорт шилжүүлж, 5.7 пунктээр өссөн байна.		
6.	2.3.1.6 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, олсон орлого, нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгийг битүүмжлэн хамгаалах арга хэмжээг авч хохирол нөхөн төлүүлэлтийг урьд оны мөн үеэс нэмэгдүүлэх;	Хувь	Өмнөх оны мөн үетэй харьцуулвал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.	Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг 5.0 хувиар ахиулсан байна.	Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг 5.0 хувиар ахиулсан байна.
7.	2.3.1.7 Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичих, үр дүнг тооцох чиглэлээр УССГХ-тэй хамтран ажиллах;	Хувь	2020 онд эрх бүхий албан тушаалтанд мөрдөгчийн 103 мэдэгдэл бичсэн. 65 /63.1/ мэдэгдлийн хариуг хүлээн авсан. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулахаар 43 албан бичгийг хүргүүлэн 35 /81.4/ хариу авсан. Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 61.8 хувьд мэдэлдэл, зөрчил арилгуулах албан бичиг бичсэн үзүүлэлттэй байна.	*Мэдэгдлийн тоо өссөн байх; *Мэдэгдлийн хариуг мэдэгдэл хүргүүлсэн хуулийн этгээдээс 100 хувь хүлээн авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх;	*Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн хэргийн 50-иас дээш хувьд нь мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байх; *Мэдэгдлийн хариуг мэдэгдэл хүргүүлсэн хуулийн этгээдээс 100 хувь хүлээн авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх;
8.	2.3.1.8 Гомдол, мэдээлэл, гэмт хэргийн тоо бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, шаардлагатай тайлан мэдээг гаргах, дүн шинжилгээ хийх;	Тайлан мэдээний тоо	2020.01.01-ний өдрөөс шинэ цахим санг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн тул улсын нэгдсэн статистикийг бүрдүүлэх нөхцөл хангагдсан.	*Санд мэдээллийг бүрэн оруулж, статистик мэдээ бүрэн гарах нөхцлийг хангасан байх; *Тогтоосон хугацаанд тайлан мэдээг гаргаж, зохих журмын дагуу ҮСХ болон эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байх;	*Санд мэдээллийг бүрэн оруулж, статистик мэдээ бүрэн гарах нөхцлийг хангасан байх; *Санд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн шаардлагатай мэдээ, судалгаа үндэслэлтэй гардаг болсон байх;

---000---



**ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**
/ 3.2. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ/

№	Эрх зүйн акт	Зорилтын	Арга хэмжээний
		Тоо	
1.	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах;	1	11
2.	Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх;	1	3
3.	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;	1	1
4.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;	1	6
5.	Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;	1	1
6.	Байгууллагын болон албан хаагчийн аюулгүй байдлыг хангах;	2	8???
7.	Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	5	14
Нийт		8	44???

---000---

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА

Гүйцэтгэлийн зорилт №3.1.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.1 дүгээр арга хэмжээ- Хүний нөөцийн програмыг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 23.1.4, 23.1.6, 23.1.10				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Байгууллагын төсөвт тусгагдсан хэмжээгээр				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням, АБХШНА, Ахлах комиссар Т.Энхболд				
	Суурь түвшин	*Хүний нөөцийн програм хангамж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон Ухаалаг засаглал ТББ-аар гүйцэтгүүлэв. Нийт албан хаагчдын мэдээллийг үзүүлэлт тус бүрээр оруулж, үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлээд байна. Цаашид судалгааг бүхий л төрлөөр гаргах хөгжүүлэлтийг хийхээр ажиллаж байна.				
	Шалгуур үзүүлэлт	*Хүний нөөцийн програмаас гаргах мэдээллийн жагсаалтыг эцэслэн боловсруулсан байх; *Програмын хөгжүүлэлтийг тухай бүр хийж, мэдээ, тайлан саадгүй, бүх төлөөр гардаг болсон байх;				
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд: *Хүний нөөцийн програмаас гаргах мэдээллийн жагсаалтыг эцэслэн боловсруулсан байх; *Програмын хөгжүүлэлтийг тухай бүр хийсэн байх; 2-4 дүгээр улиралд: *Судалгааг бүх төрлөөр гарах авах, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.2 дугаар арга хэмжээ- Албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 23.1.4, 23.1.6, Төрийн албаны тухай хууль, 55 дугаар зүйл				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Байгууллагын төсөвт тусгагдсан хэмжээгээр				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Авлигатай тэмцэх газрын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, сургалт хүний хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулахаар холбогдох судалгааг хийж, Соёмбо патнерс ТББ-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай байна. Хөтөлбөрийн төслийг хэлтэс, албадаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.				
	Шалгуур үзүүлэлт	*Хөтөлбөр батлагдаж, сурталчилгааны ажил зохион байгуулагдсан байх; *Хөтөлбөрийг хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байх;				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: *Албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөр” батлагдсан байна. *Сурталчилгааны ажил зохион байгуулагдсан байх; Сүүлийн хагас жилд: *Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханагах ажил, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна.				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.3 дугаар арга хэмжээ- Албан хаагчдын ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах, албан хаагч өөрийгөө хөгжүүлэх санал, санаачлагыг дэмжих;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 23.1.4, 23.1.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Байгууллагын төсөвт тусгагдсан хэмжээгээр				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				

	Суурь түвшин	Албан хаагчдын ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөний дагуу жил тутамд сургалт зохион байгуулагддаг. Удирдлагын академид төрийн албан хаагчдын сургалт тогтмол зохион байгуулагдах болсон.
	Шалгуур үзүүлэлт	*Сургалт төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан байх;
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд *Албан хаагчдын ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх 2021 оны сургалтын төлөвлөгөө батлагдсан байх; 1-4 дүгээр улиралд Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулагдаж, албан хаагчид байгууллагын болон бусад хэрэгцээт сургалтад хамрагдан суралцсан байх, албан хаагчаас мэргэжлийн мэдлэг, боловсролын зэргээ ахиулах сургалтад хамрагдах санал санаачлагыг дэмжиж шийдвэрийг албажуулсан байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.4 дүгээр арга хэмжээ- Албан хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 23.1.4, 23.1.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Байгууллагын төсөвт тусгагдсан хэмжээгээр				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	Албан хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулж ирсэн.				
	Шалгуур үзүүлэлт	*Төлөвлөгөө батлагдсан байх; *Спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулсан байх; *Бусад байгууллагуудаас зохион байгуулж байгаа тэмцээн уралдаанд оролцсон байх;				
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд *Төлөвлөгөө батлагдсан байх; 1-4 дүгээр улиралд *Спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулсан байх; *Бусад байгууллагуудаас зохион байгуулж байгаа тэмцээн уралдаанд оролцсон байх;				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.5 дугаар арга хэмжээ- Төрийн албаны стандартын удирдлагын хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бусад ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 23.1.4, 23.1.6, Төрийн албаны тухай хууль				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-Байгууллагын дотоод журам, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, журамд заасан тусламж, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх, шагналыг урамшил олгох гэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө /заасан хэмжээгээр/, байгууллагын төсөвт тусгаснаар,				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохих арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Төрийн албаны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ батлагдснаар зарим бүртгэл, судалгааг шинэчлэх, шинээр боловсруулах шаардлагатай байгаа.				
	Шалгуур үзүүлэлт	*Албан хаагчидтай холбоотой бүх төрлийн судалгаа хийгдэж, эрх бүхий байгууллагад шардлагатай мэдээ, судалгаа хүргэгдсэн байх; *Албан хаагчийн төрийн алба хаах болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудал зохих журмын дагуу шийдвэрлэгдэж, албан хаагчийн эрх ашиг хамгаалагдсан байх; *Зохих бүртгэл хөтөлөгдсөн, хувийн хэрэгт баяжилт хийгдсэн байх; *Стандартын удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах бусад ажил, арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байх;				
	Хүрэх түвшин	*Албан хаагчдыг албан тушаалд томилох, чөлөөлөх, хүний нөөцийн судалгаа, сонгон шалгаруулалт зохих журмын дагуу явагдсан байна. *Албан хаагчдын болон иргэдийн өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. *Төрийн болон бусад, яам агентлаг, бусад байгууллагын болон АТГ-ын шагналд албан хаагчдыг тодорхойлох, нэр дэвшүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх; *Хариуцлага ногдуулсан албан хаагчдын нэгдсэн бүртгэл хөтлөх; *Төрийн албаны болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрүүд зохих журмын дагуу албажсан байна. /тусламж дэмжлэг үзүүлсэн, тусламж, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлсэн албан хаагчдын, төрийн болон цэргийн алба хаасан хугацааны, сургалтад хамрагдсан гэх зэрэг/ *Албан хаагчийн нөөцийн бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлсөн байх;				

		*Албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт хангагдсан байна. *Төрийн албаны зөвлөлд албан хаагчийн хөдөлгөөний мэдээ зохих журмын дагуу хугацаандаа хүргэгдсэн байна. *Бусад судалгаа бүрэн хийгдсэн, үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн байна. *Хүний нөөц, сургалтын чиглэлээр хэлтэс, албадад зөвлөмж, мэдээллийг хүргүүлсэн байна. *Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах, архивт шилжүүлэх шаардлагатай хувийн хэргийг зохих журмын дагуу жил тутамд архивт шилжүүлсэн байна. *Хүний нөөц, хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгаааллын талаарх шаардлагатай мэдээлэл бэлтгэх, эрх бүхий албан тушаалтныг тухай бүр мэдээллээр хангасан байна.
--	--	---

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.6 дугаар арга хэмжээ- Байгууллагын дотоод зохион байгуулалтын ажлыг хариуцан гүйцэтгэх;					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, Хэлтэс, албадын үйл ажиллагааны уялдааг хангаж дотоод зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх Тамгын хэлтсийн чиг үүрэг				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	Хэлтэс, албадын үйл ажиллагааны уялдааг хангаж дотоод зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх Тамгын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа.				
	Шалгуур үзүүлэлт	*Байгууллагын дотоод ажлыг хариуцан гүйцэтгэсэн байх; *Зөрчил дутагдал гаргаагүй байна.				
	Хүрэх түвшин	*Дотоод мэдээллийн цаг тогтмолжсон байна. *Хэлтэс, албад шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангагдсан байна. *Хэлтсийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлийг тухай бүр зохих журмын дагуу гаргаж, хяналт үнэлгээ хийсэн байх, зөвлөмжийг хэлтэс, албадад хүргүүлсэн байна. *Даргын зөвлөлийн болон шуурхай зөвлөгөөн, байгууллагын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хийгдэж байгаа хурал, зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаж, явцыг болон шийдвэрийг зохих журмын дагуу албажуулсан байна. *Шийдвэр болон үүрэг даалгаврын гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж, авах арга хэмжээний санал танилцуулж шийдвэрлүүлж байна. *Байгууллагын танилцуулга болон бусад шаардлагатай танилцуулга, мэдээллийг нэгтгэн боловсруулсан байна. *УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр батлагдсан бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулах, эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу хүргүүлсэн байна. *Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж дүгнэсэн байна. *Тухайн жилд үүсч хөтлөгдсөн баримтуудыг эмхэлж Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт шилжүүлсэн байна.				

Гүйцэтгэлийн зорилт №3.1.1.7. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Эрх зүйн акт: Архивын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, Төрийн албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Албан хэрэг хөтлөлтийн стандарт холбогдох бусад эрхийн акт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.7 дугаар арга хэмжээ- Байгууллагын архивыг бүрдүүлэх					
	Төлөвлөлтийн уялдаа:	Авлигын эсрэг хууль, Архивын тухай хууль				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Байгууллагын төсөөт тусгагдсан хэмжээгээр				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, 2019 онд үүсч хөтлөгдсөн нийт 1081 /Тамгын хэлтэс 89, УСГХ 8, ХШДХХ 837, МШХ 58, АБХШНА 9, СААА 75, США-5/, 2013-2018 онд үүсч хөтлөгдсөн үлдэгдэл 200 хадгаламжийн нэгж, 176 хувийн хэргийг хүлээн авч архивлав. Үндэсний төв архивт УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны байнга хадгалах 203 хадгаламжийн нэгжийг, Төрийн болон албан нууцын тухай хуульд заасны дагуу 2007-2019 оны нууцын зэрэглэлтэй баримтуудыг эмхлэн цэгцэлж, 158 боть баримтыг ГАХ-т шилжүүлэх зэргээр “Байгууллагын архивын ажлын заавар”, журам, холбогдох бусад				

		хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад үйл ажиллагааны онцлогийг харгалзан 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулсан. 2019 онд үүсч хөтлөгдсөн буюу 2019 оны А,Б тушаал /547 хуудас/-ыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны байнга хадгалах 203 хадгаламжийн нэгжийг Үндэсний төв архивт актаар шилжүүлсэн. 2007-2012 онд үүсч хөтлөгдсөн байнга хадгалах 775, түр хадгалах 416, 70 жил хадгалагдах 29, байгууллагад байнга хадгалагдах 143, хуульд заасны дагуу устгалд оруулбал зохих 811 хадгаламжийн нэгжийг эмхлэн бүртгэл, товъёогийг бэлтгэн Үндэсний төв архивын бичиг баримтыг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болголоо.
	Шалгуур үзүүлэлт	* Архивын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан биелэлт, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээний биелэлтийн талаар тайлан гаргасан байх; *Архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, албадаас эмхлэн цэгцлэгдсэн баримтуудыг хүлээн авсан байх; *Тухайн жилд зохион бүрдүүлсэн баримтуудыг бүрдүүлж, нэгж үүсгэн архивт шилжүүлсэн байдлыг шалгаж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авсан байх; *Архивт хүлээн авсан баримтад тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичиг хөтөлсөн байх; *Байгууллагын удирдлага, хэлтэс, албад, бусад этгээдийг архивын мэдээллээр хангасан байх; *Байгууллага, иргэдийн хүсэлтээр архивын лавлагаа олгосон байх; *2020 онд үүсч хөтлөгдсөн баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байх; *Архивын ажлын талаар аргазүйн туслалцаа үзүүлсэн байх; *Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулсан байх; *Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтанд баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах зорилго бүхий байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комисс /ББНШК/-ын хуралдааны нарийн бичгийн даргын хувьд хуралдааны бэлтгэл ажлыг хангах, гарсан шийдвэр, үйл явцыг албажуулж, бүртгэл хөтөлсөн байх; *Хадгаламжийн санд баримтуудыг зохих журмын дагуу байршуулсан байх; *Баримтын хадгалалтын горимд хяналт тавьж, шаардлага хангуулах арга хэмжээ авсан байх; *Хадгаламжийн нэгжийн тоо бүртгэл хөтөлсөн байх; *Тухайн жилд Төв архивт шилжүүлбэл зохих баримтуудын жагсаалт гарган бүрдлийг хангаж шилжүүлсэн байх;
	Хүрэх түвшин	1 дүгээр улиралд *Архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, албадаас эмхлэн цэгцлэгдсэн баримтуудыг хүлээн авсан байна. *Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулсан байна. *2020 онд үүсч хөтлөгдсөн баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. *Архивын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангасан байх; биелэлт, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээний биелэлтийн талаар тайлан гаргасан байна. 2 дугаар улиралд *Тухайн жилд зохион бүрдүүлсэн баримтуудыг бүрдүүлж, нэгж үүсгэн архивт шилжүүлсэн байдлыг шалгаж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авсан байна. *2020 онд үүсч хөтлөгдсөн баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. *Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтанд баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах зорилго бүхий байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комисс /ББНШК/-ын хуралдааны нарийн бичгийн даргын хувьд хуралдааны бэлтгэл ажлыг хангах, гарсан шийдвэр, үйл явцыг албажуулж, бүртгэл хөтөлсөн байна. /жилд 2 удаа/ *Архивын жилийн ажлын төлөвлөгөө хэрэгжилтийг хангасан байна. *Тухайн жилд Төв архивт шилжүүлбэл зохих баримтуудын жагсаалт гарган бүрдлийг хангаж шилжүүлсэн байна. 1-4 дүгээр улиралд Байгууллагын удирдлага, хэлтэс, албад, бусад этгээдийг архивын мэдээллээр хангасан байна. *Байгууллага, иргэдийн хүсэлтээр архивын лавлагаа олгосон байна. *Баримтын хадгалалтын горимд хяналт тавьж, шаардлага хангуулах арга хэмжээ авсан байна. *Хадгаламжийн нэгжийн тоо бүртгэл хөтөлсөн байна. *Архивт хүлээн авсан баримтад тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичиг хөтөлсөн байна. *Архивын ажлын талаар аргазүйн туслалцаа үзүүлсэн байна. *Хадгаламжийн санд баримтуудыг зохих журмын дагуу байршуулсан байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.8 дугаар арга хэмжээ-" Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх хадгалах журам "-ын хэрэгжилтийг хангах

Арга хэмжээний нэр, дугаар	Төлөвлөлтийн уялдаа:	Архивын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх хадгалах журам, Албан хэрэг хөтлөлтийн стандарт холбогдох бусад эрхийн акт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Тамгын хэлтэс, Эрхэлсэн комиссар З.Баасанням				
	Суурь түвшин	2020 онд нийтдээ 62011 хэвлэмэл хуудсыг дугаарлаж, үйл ажиллагаанд ашигласан байна. Хэвлэмэл хуудасны зарцуулалт, устгалын бүртгэлийг зохих журмын дагуу тогтмол хийж, тайланг улирлаар гарган тооцоо нийлэн ажиллаж байна. “Хуулбар үнэн дардас”-ыг 23212 хуудас баримт бичигт дарж бүртгэлээр албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.				
